



## Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо

# ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ

2023 ОНЫ 08 САРЫН 16-НЫ  
ӨДРӨӨС ХҮЧИН ТӨГӨЛДӨР  
ҮЙЛЧИЛНЭ



## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УСАН СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ**

1. МУССХ-НЫ УСАН СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ, ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
2. МУССХ-НЫ ТЭМЦЭЭНҮҮД БОЛОН ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ
3. ТАМИРЧНЫ ХАРЬЯАЛАЛ, БАЙГУУЛЛАГА КЛУБЫГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ
4. ТЭМЦЭЭНИЙ ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ТӨРӨЛ
5. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ БОЛОН РЕКОРД АМЖИЛТ ТОГТООХОД ТАВИХ ШААРДЛАГА
6. ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ
7. ТЭМЦЭЭНИЙ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ
8. ТАНИХ ТЭМДЭГ, СУРТАЛЧИЛГАА
9. ТАМИРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ
10. ТЭМЦЭЭНИЙ БАЙГУУЛАМЖ
11. ШҮҮГЧДИЙН БАГ
12. ЦОМ, МЕДАЛЬ, ОНОО
13. ЭСЭРГҮҮЦЭЛ БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ



## **1. МУССХ-НЫ УСАН СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ, ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

1.1 Зөвхөн МУССХ нь усанд сэлэлт, өндрөөс үсрэлт, усан поло, уран сайхны сэлэлт, задгай усан сэлэлтийн Насанд хүрэгчдийн болон Өсвөр үе, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах эрхтэй. Улсын болон МУССХ гэдэг үгийг усанд сэлэлт, өндрөөс үсрэлт, усан поло, уран сайхны сэлэлт, задгай усанд сэлэлтийн аливаа тэмцээн, арга хэмжээнд зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглоно.

1.2 МУССХ-ны Удирдах зөвлөл нь усан спортын бүх төрлийн тэмцээнийг зохион байгуулахтай холбоотой дүрэм, журмыг тогтоох эрхтэй бөгөөд энэ нь Дэлхийн усан спортын холбоо буюу World Aquatics-ийн холбогдох дүрэм журмын хүрээнд байна.

1.3 МУССХ-ны зохион байгуулж буй бүх тэмцээний менежментийн баг нь Удирдах зөвлөлийн гишүүдээс бүрдэх бөгөөд тус баг нь Давж заалдах шатны шүүгчийн үүргийг гүйцэтгэнэ.

1.4 МУССХ-ны зохион байгуулж буй бүх тэмцээний Шүүгчдийн багийг тухайн мэргэжлийн зөвлөл буюу Шүүгчдийн зөвлөл санал болгох бөгөөд ЕНБД нь Удирдах зөвлөлд санал оруулан батлуулна.

1.5 МУССХ-ны зохион байгуулж буй бүх тэмцээний уралдааны зохион байгуулах хороо нь:

- Дарга
- Дэд дарга
- Мэрэгжлийн зөвлөлүүд
- Нарийн бичиг болон менежментийн багийн төлөөлөл гэсэн бүтэцтэй байх бөгөөд Удирдах зөвлөл бүрэлдэхүүнийг батална.

1.6 Тэмцээний зохион байгуулах хороо нь доорхи ажлуудыг хариуцан ажиллана.

а) Тэмцээний төсвийг гаргаж батлуулах

б) Тэмцээнийг дүрэм журмын дагуу зохион байгуулах

в) Тэмцээний өмнө болон тэмцээний үеэр бүх техник, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа болон суурилуулалтыг хянах

г) Тэмцээн зохион байгуулагчдын ажил үүргийн хуваарийг гаргах

д) Ерөнхий шүүгчийн шийдвэрийг давж заалдсан эсэргүүцлийг Давж заалдах шатны шүүх ажиллагаанд бэлтгэх зорилгоор хянаж, шалгах.

1.7 Улс төрийн үйл ажиллагаа

Тэмцээн болж буй газар болон түүний ойролцоо улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.



Тэмцээний өмнө болон тэмцээний дараа ч тухайн тэмцээн болж буй газар болон түүний ойролцоо бүх төрлийн улс төрийн агуулгатай сурталчилгаа, мэдээлэл хийх, бусад улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглоно.

#### 1.8 Өдөөн хатгасан үйлдэл болон ялгаварлан гадуурхалт

Тэмцээнийг зохион байгуулагчид тэмцээн болох газар болон ойр орчимд нь үзэгчдийг өдөөн хатгасан аливаа үйлдэл (үзэгчдээс тамирчдад болон эсрэг талын хөгжөөн дэмжигчдэд чиглэсэн үг хэлээр өдөөн хатгах, ялгаварлан гадуурхах зан үйл, өдөөн хатгасан утга бүхий хэвлэмэл материал, туг далбаа гэх мэт) гаргахаас урьдчилан сэргийлэх ёстой. Хэрэв ийм үйлдэл гарвал тэмцээнийг зохион байгуулагчид тус үйлдлийг таслан зогсоож, өдөөн хатгасан утга бүхий материалыг хураан авах бөгөөд шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын тусламжийг авна. Зохион байгуулагчид нь өдөөн хатгасан, ялгаварлан гадуурхаж доромжлох зэрэг ноцтой ёс бус үйлдэлд цагдаагийн тусламжийг зайлшгүй авах бөгөөд тэдний шийдвэрээр зөрчил гаргагчийг тэмцээн болж буй газраас гаргана.

## 2. МУССХ-НЫ ТЭМЦЭЭНҮҮД БОЛОН ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ

2.1 МУССХ-ны тэмцээн гэж МУССХ-ны зохион байгуулж буй усан спортын бүх төрлийн тэмцээнүүд, мөн түүний гишүүн байгууллага, клуб, хувь хүн болон бусад хамтран ажиллагч байгууллагуудын зохион байгуулж буй МУССХ-ны зүгээс хүлээн зөвшөөрсөн аливаа тэмцээнийг хэлнэ. Зөвхөн МУССХ-ны тэмцээний үеэр тогтоогдсон рекорд амжилтыг хүлээн зөвшөөрөх бөгөөд спортын зэрэг цол олгоно.

2.2 МУССХ-ны тэмцээн дараахи зэрэглэлтэй байна.

А Зэрэглэл: Насанд хүрэгчдийн (14 нас болон түүнээс дээш нас) болон Өсвөр үе, залуучуудын (7-18 нас), Мастерсуудын (25- дээш нас) улсын аварга шалгаруулах усан спортын тэмцээнүүд

В Зэрэглэл: Ерөнхийлөгчийн нэрэмжит цомын тэмцээн болон клубуудын цом зэрэг усан спортын тэмцээн

С Зэрэглэл: МУССХ-ны зүгээс хүлээн зөвшөөрсөн түүний гишүүн байгууллага, клуб, хувь хүн болон бусад хамтран ажиллагч байгууллагуудын зохион байгуулж буй усан спортын тэмцээнүүд

2.3 МУССХ-ны тэмцээний хуваарь

2.3.1 МУССХ-ны Удирдах зөвлөл тухайн жилд болох усан спортын бүх тэмцээний хуваарийг, олимпийн циклд тохируулах зарчмаар батлах бөгөөд цахим хуудсандаа нийтэлнэ.

Жилийн хуваарь гарснаас хойш ирсэн аливаа шинэ тэмцээний саналыг өмнө батлагдсан тэмцээнүүдтэй цаг хугацааны хувьд давхцахааргүй байдлаар зохицуулан баталж болно.

Бүх зэрэглэлийн тэмцээний хуваарийг батлахдаа тэмцээн уралдааныг 1-р зэрэглэлийн тэмцээн болохоос 30 хоногоос дотогш хугацаанд зохион байгуулахгүй байх бодлогыг баримтална.



2.3.2 МУССХ-ны (1 болон 2-р зэрэглэл) болон түүний зөвшөөрлөөр хийгдэж байгаа 3-р зэрэглэлийн тэмцээнийг цуцлах, эсвэл шинээр товлох тухай асуудлыг тухайн тэмцээн эхлэхээс аль болох өмнө МУССХ-ны Удирдах зөвлөлд мэдэгдэнэ.

## 2.4 Тэмцээний хөтөлбөр

2.4.1 МУССХ-ны зохион байгуулж буй 1-р зэрэглэлийн тэмцээнд усан спортын тухайн төрлийн бүх зай, төрлийг багтаасан байна. 2-р зэрэглэлийн тэмцээний хувьд тэмцээний хөтөлбөрт боломжтой бол усан спортын тухайн төрлийн бүх зай, төрлийг багтаахыг эрмэлзэнэ. 3-р зэрэглэлийн тэмцээний хувьд усан спортын тухайн төрлийн зай, төрөлд ямар нэг өөрчлөлт оруулахыг хүсэж байгаа бол энэ талаар Удирдах зөвлөлд тэмцээнийг батлуулахаар гаргасан өргөдөлдөө тусгасан байна.

2.4.2 Аливаа тэмцээнийг Удирдах зөвлөлөөр батлуулах хүсэлтэд тухайн тэмцээнд хамаарах МУССХ-ны дүрэм, журмын өөрчлөлтийг (хэрэв байгаа бол) заавал тусгасан байна.

2.4.3 Дүрмийн энэхүү 2-р зүйлийг дагаж мөрдөхгүй байх нь МУССХ-ны дүрмийн зөрчсөнд тооцогдох бөгөөд тухайн тэмцээнийг хориглох үндэслэл болно.

## 3. ТАМИРЧНЫ ХАРЬЯАЛАЛ, БАЙГУУЛЛАГА КЛУБЫГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ

### 3.1 Тамирчны харьяалал, байгууллага клубыг төлөөлөх эрх

3.1.1 МУССХ-ны бүх төрлийн тэмцээнд оролцож байгаа тамирчин МУССХ-ны гишүүн байгууллага, клуб болон хамтран ажилладаг байгууллагыг төлөөлж оролцохоос гадна хувиараа оролцож болно. Аливаа байгууллага клубыг төлөөлөн оролцохын тулд тамирчин нь:

- Тухайн байгууллага, клубынхаа гишүүн байх
- Тухайн байгууллага, клубтээ тасралтгүй нэг (1) сараас дээш хугацаагаар харьяалагдан бэлтгэл сургуулилт хийсэн байна
- Тамирчин нь гадаадад бэлтгэл сургуулилтаа хийж, гадаад улсын клубын давхар гишүүнчлэлтэй байж болно. Харин Монгол улсдаа зөвхөн нэг клубыг төлөөлөн тэмцээнд оролцоно.
- Тамирчин нь ивээн тэтгэгч байгууллагын нэрийг ашиглаж болно.

### 3.2. Тамирчин харьяалалаа өөрчлөх

3.2.1 Тамирчин өөрийн харьяалдаг байгууллага клубыг өөрчлөхөөр шийдсэн бол энэ талаар өөрийн харьяалагдаж байгаа байгууллага, клуб болон МУССХ-ны ЕНБД-д бичгээр мэдэгдэнэ.



Тамирчин насанд хүрээгүй бол түүний эцэг эх, асран хамгаалагчид өмнөөс нь мэдэгдлийг гаргана. Мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш доорхи шаардлага хангагдсан бол тухайн тамирчин шинэ клубээ төлөөлөн тэмцээнд оролцох эрхтэй болно.

- Тамирчин хуучин харьяалагддаг байгууллага, клуб болон МУССХ-ны ЕНБД-д харьяалал өөрчлөх тухай мэдэгдлээ өгснөөс хойш дор хаяж нэг (1) сар өнгөрсөн байх
- Тамирчин шинэ клубынхаа гишүүн болсон байх

### 3.3 Тамирчны харьяалалын дүрмийн зөрчил

3.3.1 Харьяаллын талаарх дүрмийг зөрчсөн тохиолдолд МУССХ-ны дүрэм, Ёс зүйн дүрмийн дагуу шалгалтын ажиллагаа явуулж, хянан шийдвэрлэх эрхийг МУССХ-ны Ёс зүйн зөвлөл эдлэнэ.

3.3.2 Ёс зүйн зөвлөл нь Ёс зүйн дүрмэнд заасны дагуу зөрчилд тохирох шийтгэлийг ноогдуулахаас гадна тус тамирчны тухайн тэмцээнд оролцох эрхийг хасах боломжтой.

Тамирчны харьяаллын дүрмийг зөрчиж оролцсон тэмцээний бүх шагнал, медаль, оноо, цолыг хураана.

### 3.4. Тамирчны харьяаллын дүрмийг хэрэгжүүлэх

Энэхүү дүрэм нь 2023 оны 08-р сарын 16 -ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд буцаан хэрэглэхгүй. Тамирчин энэхүү шинэ дүрэм хүчин төгөлдөр болохоос өмнө харьяалалаа өөрчлөх үйл явцаа эхлүүлсэн байсан бол энэхүү дүрмийг хэрэглэхгүй. Шаардлагатай тохиолдолд тамирчин үүнийгээ нотлох үүрэгтэй.

## 4. ТЭМЦЭЭНИЙ ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ТӨРӨЛ

МУССХ нь усан спортын бүх тамирчдад аюулгүй, шударга, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхалгүйгээр тэмцээндээ оролцох боломж олгохыг эрмэлзэж ажиллана. Шударга өрсөлдөөнийг хангах зорилгоор тэмцээнийг эрэгтэй, эмэгтэй хүйсийн ангилалаар зохион байгуулах бөгөөд хүйсийн асуудлаар үүсэх аливаа маргааныг Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны Competition regulations-ын 1-р бүлгийн 5.2-5.6 зүйлийн заалтуудыг мөрдлөг болгон шийдвэрлэнэ.

## 5. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ БОЛОН РЕКОРД АМЖИЛТ ТОГТООХОД ТАВИХ ШААРДЛАГА

5.1 МУССХ-ны тэмцээнд оролцох тамирчид доорхи ерөнхий шаардлагын дагуу тэмцээнд оролцох болон Монгол Улсын рекорд амжилтаа бүртгүүлэх эрхтэй.



5.2 Тамирчин тэмцээнд оролцоходоо МУССХ-ны гишүүн байгууллага, клубыг төлөөлөн оролцохоос гадна хувиараа оролцож болно.

5.3 Тамирчид усан спортын тэмцээнд зөвхөн өөрийн хромсомын хүйсийн ангилалд л өрсөлдөх эрхтэй. (трансжендер болон хүйс солиулсан тамирчид Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны Competition regulations-ын 1-р бүлгийн 5.4 болон 5.5 зүйлийн заалтуудыг баримтлан тэмцээнд оролцоно).

5.4 Зөвхөн Монгол улсын иргэн МУССХ-ны хүлээн зөвшөөрсөн тэмцээнүүд болон гадаад улсад болсон албан ёсны протоколтой тэмцээнүүд, олон улсын чанартай тэмцээнд оролцож усан спортын Монгол Улсын рекорд амжилтыг тогтоож, тэмдэглүүлэх эрхтэй.

5.5 Насны ангилалтай тэмцээнд зөвхөн өөрийн насны ангилалд өрсөлдөж, тухайн насны ангилалдаа рекорд амжилт тогтоож тэмдэглүүлэх эрхтэй.

5.6 Ямар ч тамирчныг хууль ёсны хүйс, хүйсийн баримжаа болон хүйсийн өөрчлөлтөнд үндэслэн МУССХ-ны усан спортын тэмцээнд оролцох эсвэл усан спортын улсын рекорд амжилтыг тогтоох эрхийг хасч болохгүй.

5.7 Хүйсийн маргаантай тамирчин ямар хүйсийн ангилалд өрсөлдөхийг МУССХ-ны ЕНБД болон Судалгаа шинжилгээний баг хамтран, нэг буюу хэд хэдэн бие даасан шинжлэх ухаан, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдсөний дараа тогтооно. Үүний тулд МУССХ нь тамирчнаас нэмэлт мэдээлэл, бичиг баримт гаргаж өгөх, эсвэл эрүүл мэндийн үзлэгт хамрагдахыг хүсч болно. Энэхүү үнэлгээтэй холбоотой бүх зардлыг МУССХ хариуцна.

5.8 Өөрийн нас, хууль ёсны хүйс, хүйсийн баримжаа болон хүйсийн өөрчлөлтийн талаархи мэдээллийг хуурамчаар мэдээлсэн тамирчинд МУССХ-ны дүрэм болон Ёс зүйн дүрмийн хүрээнд хариуцлага тооцож, тэмцээнд оролцох эрхийг хасна.

## **6. ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ**

6.1 Тэмцээний мэдээлэл болон бүртгэлийн хугацааг МУССХ-ны цахим хуудсаар болон гишүүн байгууллага, клубуудад цахим шуудан илгээж мэдээлнэ. МУССХ-ны гишүүн байгууллага, клуб болон хувиараа оролцож буй тамирчин тэмцээнд оролцох тамирчдынхаа "мэдүүлэг"-ийг тэмцээн эхлэхээс 30 хоногийн өмнө илгээх ёстой.

6.2 Тэмцээн зохион байгуулах хороо нь бүртгүүлсэн бүх тамирчдыг зохих журмын дагуу шалгаж, тэмцээнд оролцох эрхийг нь баталгаажуулна.

6.3 Техникийн зөвөлгөөнд бүх багийн ахлагчид оролцох шаардлагатай бөгөөд хүндэтгэх шалтгаангүйгээр оролцоогүй багийн ахлагчид 100'000 төгрөгийн торгууль ноогдуулна.



Торгуулийг төлсний дараа багийн тэмцээнд оролцох эрх нээгдэнэ.

6.4 Эрүүл мэндийн шалтгаанаас бусад тохиолдолд баг /тамирчин тэмцээний урьдчилсан тоглолт/гараанд гараагүй бол тамирчныг 50,000 төгрөгөөр, бүүхиа болон багийн спортын төрөлд 100,000 төгрөгөөр торгоно.

6.5 Эрүүл мэндийн шалтгаанаар тоглолт/гараанд гараагүй тамирчин тухайн өдрийн бусад тоглолт/гараанд оролцох эрхгүй.

6.6 Хагас шигшээ болон шигшээ тоглолт /уралдаанд шалгарсан баг/ тамирчин тэмцээнд үргэлжлүүлэн оролцохгүй болсон бол тэмцээн эхлэхээс 30 минутын дотор буюу хагас шигшээ, шигшээ тоглолт/гарааны хуваарь гарахаас өмнө мэдэгдэх үүрэгтэй. Энэ хугацаанд хүсэлтээ гаргаагүй бол шалтгааныг үл харгалзан багийг /Бухиа/ 200,000 төгрөг, тамирчныг 100,000 төгрөгөөр торгоно.

6.7 Усанд сэлэх, шумбах, уран сайхны сэлэлтийн төрөлд хагас шигшээ болон шигшээ тоглолтонд өрсөлдсөн тамирчин ямар нэг шалтгаанаар хасагдсан тохиолдолд түүний эзэлсэн байр, шагналыг дараагийн тамирчинд олгоно. Хагас шигшээ эсвэл шигшээд оролцсон бүх тамирчид нэг байр урагшилна. Шагнал гардуулсны дараа эрхээ хасуулсан тохиолдолд шагналыг буцаан хурааж, дээр дурдсан заалтуудыг баримтлан зохих өрсөлдөгчид олгоно.

6.8 Тэмцээнийг зохион байгуулагчдын буруутай үйлдлээс болж баг, тамирчин ямар нэг алдаа гаргаж шийтгэл хүлээсэн нь тогтоогдвол баг, тамирчны шийтгэлийг нэн даруй хүчингүй болгож амжилтыг сэргээж, цаашид тэмцээнээ үргэлжлүүлэх боломжоор хангана.

6.9 Тэмцээнд оролцогчдын гарааны дараалал, хуваарийг тэмцээн эхлэхээс доор хаяж 5 /ажлын/ хоногийн өмнө нийтэлсэн байна.

## **7. ТЭМЦЭЭНИЙ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ**

7.1 Баг, тамирчдын тэмцээний хувцас хэрэглэл Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны Competition regulations-ын 1-р бүлгийн 7 зүйлд заасан хувцас хэрэглэлийн ерөнхий стадартыг хангасан байна.

7.2 Усны өмсгөл болох усны хувцас, малгай, усны шил нь усан спортын тухайн төрөлд тохирсон байх бөгөөд ямар нэгэн сөрөг сэтгэгдэл төрүүлэх тэмдэг, тэмдэглэгээгүй байна.

7.3 Усны өмсгөлийн өнгө тунгалаг/гэрэлтэж харагддаг/ байж болохгүй. Хоёр (2) давхар малгай өмсч болно.

7.4 Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны хувцасны стандарт болон энэхүү дүрмийн ерөнхий шаардлагыг илт зөрчсөн хувцас хэрэглэлтэй тамирчинд Ерөнхий шүүгч зөрчлийг арилгах шаардлага тавих бөгөөд шаардлагыг биелүүлээгүй бол тэмцээнээс хасах эрхтэй.





## **8. ТАНИХ ТЭМДЭГ, СУРТАЛЧИЛГАА**

8.1 Баг, тамирчдын тэмцээний өмсгөл буюу усны хувцас, малгай, усны шил болон бэлтгэлийн хувцас, алчуур, гутал, цүнхэн дээр тавигдах таних тэмдэг болон сурталчилгаа нь Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны Competition regulations-ын 1-р бүлгийн 8 зүйлд ерөнхий стадартыг хангасан байна.

8.2 Тамхи болон согтууруулах ундааны сурталчилгааг хориглоно

8.3 Бие дээрх ямар нэг таних тэмдэг, сурталчилгааг хориглоно

8.4 Тамирчны харьяалагдах байгууллага, клубын нэр болон таних тэмдгийг зар сурталчилгаанд тооцохгүй.

8.5 Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны таних тэмдэг, зар сурталчилгааны стандарт болон энэхүү дүрмийн шаардлагыг илт зөрчсөн тамирчинд Ерөнхий шүүгч зөрчлийг арилгах шаардлага тавих бөгөөд шаардлагыг биелүүлээгүй, биелүүлсэн ч тэмцээнийг саатуулахаар байвал тэмцээнээс хасах эрхтэй.

## **9. ТАМИРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

### **9.1 Танилцуулга**

МУССХ нь усан спортын тамирчдын эрүүл мэндэд аюул учруулахгүйгээр, шударга өрсөлдөөн, спортын ёс зүйг дээдлэн ажиллах үүрэгтэй. Үүний тулд тамирчдын эрүүл мэндийг сахин хамгаалах, бие махбодийн болон сэтгэл зүйн гэмтэл, эрсдлийг бууруулах чиглэлд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллана.

### **9.2 Хамрах хүрээ**

Тамирчны эрүүл мэнд, аюулгүй байдлын дүрэм нь МУССХ-ны усан спортын бүх төрлийн тэмцээнд оролцож буй тамирчдад зориулагдсан. Энэ дүрэм нь тэмцээний үе болон тэмцээнээс гадуурхи үед ч хамаарна.

### **9.3 Тамирчид болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн хоорондын харилцаа**

9.3.1 Тамирчид эмч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчидтэй харилцахдаа бүх өвчтөнтэй адил эрхийг эдлэх бөгөөд ялангуяа тамирчдын дараахи эрхийг онцгойлон анхаарна

- тэдний нэр төр
- тэдний бие махбодийн болон оюун санааны бүрэн бүтэн байдал
- тэдний эрүүл мэнд болон аюулгүй байдлыг хамгаалах
- тэдний хувийн нууц болон нууцлал



9.3.2 Тамирчдын эрүүл мэндийг хамгаалж, аюулгүй байдлыг хангах явдал эдийн засаг, хууль эрх зүйн болон улс төрийн зэрэг бусад бүх эрх ашгаас дээгүүр тавигдах ёстой.

9.3.3 Тамирчид өөрийн эрүүл мэндийн байдал, оношилгооныхоо талаар тодорхой, зөв мэдээлэл авах эрхтэй. Үүнд: Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, санал болгож буй эмчилгээ болон эмчилгээний эрсдэл, үр дүн болон санал болгож буй эмчилгээний бусад хувилбарууд, эмчилгээ хийлгээгүйгээс үүсэж болох үр дагавар, эргээд спортоор хичээллэж болох эсэх, нөхөн сэргээх эмчилгээний үе шат, явц гэх мэт

9.3.4 Тамирчинд ямар нэг эмчилгээ хийхийн тулд заавал зөвшөөрлийг нь авах ёстой. Энэхүү зөвшөөрлийг амаар эсвэл бичгээр авч болно.

9.3.5 Тамирчны өвчин болон гэмтэл бэртлээ эмчлүүлэх шийдвэрт ойр тойрныхон (жишээлбэл, дасгалжуулагч, удирдлага, гэр бүл гэх мэт) болон бусад тамирчдын зүгээс нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэхээс сэргийлж, түүнд үнэн зөв мэдээллийг өгөхөд анхаарна

9.3.6 Тамирчин эмнэлэгийн тусламж авахаас татгалзах эрхтэй. Ийм тохиолдолд шийдвэрийн үр дагаврыг тамирчинд сайтар тайлбарлах өгөх ёстой.

9.3.7 Насанд хүрээгүй тамирчны хувьд түүний өмнөөс шийдвэрийг түүний асран хамгаалагч эсвэл багийн ахлагч гаргана.

9.3.8 Аливаа биологийн дээжийг цуглуулах, хадгалах, шинжлэх, ашиглахад тамирчдын зөвшөөрөл шаардлагатай.

9.3.9 Сэргээшийн хяналтын зорилгоор биологийн дээж өгөхөөс татгалзах нь Дэлхийн усан спортын холбооны сэргээшийн хяналтын дүрэм, МУССХ-ны дүрэм болон Ёс зүйн дүрмийн зөрчилд тооцогдоно.

#### 9.4 Хувийн нууц ба нууцлал

9.4.1 Тамирчны эрүүл мэндийн байдал, оношилгоо, таамаглал, эмчилгээ, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх бүх мэдээлэл болон бусад хувийн мэдээлэл нь нууц байх ёстой.

9.4.2 Нууцад хамаарах мэдээллийг тухайн тамирчны зөвшөөрлөөр, эсвэл хуульд тодорхой заасан тохиолдолд задруулж болно. Тамирчны эмчилгээнд шаардлагатай мэдээллийг бусад эрүүл мэндийн байгууллагад өгөхийг мэдээлэл задруулсан гэж үзэхгүй.

9.4.3 Тамирчинтай холбоотой эмнэлгийн бүх мэдээлэл хамгаалагдсан байх ёстой. Үүний нэгэн адил тамирчны биологийн дээжийг ч хамгаалах ёстой.

9.4.4 Тамирчид эрүүл мэндийн дэвтэртэйгээ танилцах, түүний хуулбарыг авах эрхтэй.

9.4.5 Тамирчид өөрийн эрүүл мэндийн талаархи алдаатай мэдээллийг засахыг шаардах эрхтэй.

9.4.6 Зөвхөн оношилгоо, эмчилгээ, асаргаа сувилгаанд шаардлагатай болон тамирчин зөвшөөрсөн эсвэл хуульд заасан тохиолдолд л тамирчны хувийн амьдралд оролцохыг



зөвшөөрнө. Сэргээшийн эсрэг аливаа дүрмийн (Дэлхийн сэргээшийн эсрэг хууль ба Дэлхийн усан спортын сэргээшийн хяналтын дүрэм) дагуу үүнийг бас зөвшөөрнө.

9.4.7 Эмчилгээний аливаа арга хэмжээ тамирчны хувийн нууцыг хүндэтгэх ёстой. Үүнийг тамирчин зөвшөөрөл олгоогүй, хүсэлт гаргаагүй л бол тухайн эмчилгээний арга хэмжээнд зөвхөн зайлшгүй шаардлагатай эмнэлэгийн албан хаагчид оролцоно гэж ойлгоно.

## 9.5 Эмчилгээ, сувилгаа

9.5.1 Тамирчин урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих болон нөхөн сэргээх зэрэг өөрийн хэрэгцээнд тохирсон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхтэй. Энэ үйлчилгээ нь хүнийг санхүүгийн болон бусад байдлаар нь ялгаварлан гадуурхахгүйгээр, бүх хүнд тэгш хүртээмжтэй байх ёстой.

9.5.2 Тамирчид гадаадад бэлтгэл сургуулилт, тэмцээнд оролцохдоо эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, шаардлагатай газраа эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах эрхтэй байх ёстой

9.5.3. Тамирчин өөрийн үйлчилгээ авах эмнэлгийн байгууллага, эмчээ сонгох мөн өөрчлөх эрхтэй. Тэд нэг асуудлаар 2 дахь эмнэлгийн дүгнэлт/оношилгоог хүсэх эрхтэй.

9.5.4. Тамирчин өөрийн хэл соёл, уламжлал, үнэт зүйлд нийцүүлэн оношилгоо, эмчилгээ, асаргаа сувилгаа, нөхөн сэргээх үйлчилгээг авах эрхтэй. Тэд асаргаа, эмчилгээний явцад гэр бүл, төрөл төрөгсөд, найз нөхдөөсөө сэтгэл санааны дэмжлэг авах эрхтэй.

9.5.5 Өвдөлт намдаах үйлчилгээтэй эмчилгээг зөвхөн тамирчин болон бусад эрүүл мэндийн ажилтнуудтай сайтар судалж, зөвлөлдсөний дараа хийнэ. Хэрэв тамирчны эрүүл мэндэд удаан хугацааны эрсдэл үүсгэхээр бол ийм эмчилгээ хийхийг хориглоно.

## 9.6 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг

9.6.1 Өнөөгийн анагаах ухааны практикт мөрдөгдөж буй ёс зүйн зарчмууд нь спортын анагаах ухаанд ижил хамаарна. Эмч болон бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн үндсэн үүрэгт дараахи зүйлс орно.

- тамирчдын эрүүл мэндийг нэн тэргүүнд тавих
- тамирчны эрүүл мэндэд хор хөнөөл учруулахгүй байх

9.6.2 Тамирчинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нь спортын анагаах ухааны чиглэлээр шаардлагатай боловсрол, сургалт, туршлагатай байхаас гадна мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж байх ёстой. Тэд бэлтгэл сургуулилт, тэмцээний үеэр тамирчдад тулгардаг бие бялдар, сэтгэл санааны сорилтууд болон тэсвэр тэвчээрийг ойлгож дэмжих чадавхитай байх ёстой.

9.6.3 Тамирчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нь хамгийн сүүлийн үеийн эмнэл зүйн арга барилыг ашиглан үйлчилгээгээ үзүүлэх ёстой. Тамирчид болон түүний туслан



дэмжигчид хүссэн ч эмнэлгийн заалтгүй аливаа арга хэмжээ авахаас татгалзана. Мөн тамирчны эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилтийн талаар худал эмнэлгийн дүгнэлт гаргахаас зайлсхийх ёстой.

9.6.4 Тамирчдын эрүүл мэнд эрсдэлд орсон үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид тэднийг үргэлжлүүлэн бэлтгэл, тэмцээн уралдаанд оролцохыг эрс хориглож, эрсдлийн талаар мэдээлэх ёстой. Тамирчинд ноцтой аюул учирсан эсвэл гуравдагч этгээдэд (нэг багийн тамирчид, өрсөлдөгчид, гэр бүлийнхэн, олон нийт гэх мэт) эрсдэл үүссэн тохиолдолд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нь тамирчны хүсэл зоригийн эсрэг, түүнийг бэлтгэл, тэмцээнд оролцох чадамжгүй талаар эрх бүхий байгууллага/албан тушаалтанд мэдэгдэнэ.

9.6.5. Эрүүл мэндийн байгууллага нь хүүхдийн өсөлт хөгжилт, эрүүл мэндийн ерөнхий байдал, бэлтгэлийн түвшинд тохирохгүй аливаа спорт, биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг эсэргүүцэх ёстой. Тэд хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн ашиг сонирхлын үүднээс тэдний туслан дэмжигчид (жишээ нь: дасгалжуулагч, удирдлага, гэр бүл гэх мэт) болон бусад тамирчдын ашиг сонирхол, дарамтыг үл харгалзан ажиллах ёстой.

9.6.6 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид гуравдагч этгээдийн нэрийн өмнөөс (жишээ нь, клуб, холбоо, зохион байгуулагчид гэх мэт) үйл ажиллагаа явуулж байгаа бол энэ талаархи мэдээлэл нь ил тод байна. Тэд тамирчдад эрүүл мэндийн үзлэг хийж буй шалтгаан, үр дүн, гуравдагч этгээдийн зүгээс өгсөн мэдээллийг тайлбарлаж өгөх ёстой. Мөн тамирчны эмчид мэдэгдэх ёстой.

9.6.7 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээдийн нэрийн өмнөөс ажиллахдаа зөвхөн зайлшгүй шаардлагатай мэдээллийг л түүнд дамжуулна. Мэдээлэл нь зөвхөн тамирчны бэлтгэлжилт болон тэмцээнд оролцох боломжтой эсэхээр хязгаарлагдана. Тамирчны зөвшөөрлөөр бусад мэдээллийг эрүүл мэндийн байдалд нь нийцүүлэн өгч болно.

9.6.8 Тэмцээний үеэр гэмтэл авсан тамирчныг тэмцээнээ үргэлжлүүлэх эсэхийг тодорхойлох нь багийн болон тэмцээний эмчийн үүрэг байна. Энэ шийдвэр гаргах эрхийг бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно. Ямар ч үед тамирчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах нь нэн тэргүүнд тавигдах ёстой. Тэмцээний болзошгүй үр дүн шийдвэр гаргалтанд хэзээ ч нөлөөлөх ёсгүй.

9.6.9. Шаардлагатай тохиолдолд багийн эсвэл тэмцээний эмч нь тамирчинд нарийн мэрэгжлийн эмчийн тусламжийг авах боломжийг хангаж өгөх ёстой.

## 9.7 Бэлтгэл, тэмцээний үеэр тамирчны эрүүл мэндийг хамгаалах

9.7.1 Тамирчны бие махбодь болон сэтгэл зүйд гэмтэл учруулах аливаа дасгал хийхийг хориглоно. Тамирчны аюулгүй байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь тэдний бие бялдар,



оюун санааны тэнцвэрт байдалд чухал нөлөө үзүүлдэг. Иймд спортын эмч нарын оролцоотойгоор осол гэмтэл, өвчний эрсдлийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

9.7.2 Бэлтгэл сургуулилт, тэмцээний үеэр тамирчид болон ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс аюулгүй байдлын наад захын шаардлагыг тодорхойлж, хэрэгжүүлнэ. Спортын төрөл, өрсөлдөөний түвшингээс хамааран тэмцээний байгууламж, хүрээлэн буй орчны аюулгүй байдлын тодорхой дүрмийг боловсруулж дагаж мөрдөнө.

9.7.3 Тамирчдын эрүүл мэндийг хамгаалах, бие махбодь, сэтгэл зүйн хохирлын эрсдлээс сэргийлэх зорилготой дүрэм журмыг хэвлэж сурталчилна.

9.7.4 Тамирчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ нь хамгийн сүүлийн үеийн хүлээн зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн мэдлэгт суурилсан байх ёстой.

9.7.5 Спортын анагаах ухаан, спортын шинжлэх ухааны судалгааг дэмжинэ. Гэхдээ судалгаа шинжилгээний ажлыг тамирчны эрүүл мэндэд хор хөнөөлтэй байдлаар хэзээ ч хийж болохгүй. Судалгааны ажилд тамирчин сайн дурын үндсэн дээр оролцож болно.

9.7.6 Спортын анагаах ухаан, спортын шинжлэх ухааны ололт амжилтыг нууж болохгүй бөгөөд олон нийтэд түгээх ёстой

## 9.8 Эмнэлгийн тусламж

9.8.1 Усан спортын төрөл бүрт үйл ажиллагааны шинж чанар, тэмцээний түвшингээс хамааран шаардлагатай эмнэлгийн тусламжийн удирдамжийг гаргана. Энэ удирдамжинд доорхи зүйлсийг тусгана. Үүнд:

- Бэлтгэл сургуулилт, тэмцээн болох газарт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хэрхэн зохион байгуулах талаар
- Шаардлагатай нөөц (хангамж, байр, тээврийн хэрэгсэл гэх мэт)
- Онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ, зохион байгуулагчид болон эрүүл мэндийн эрх бүхий байгууллагуудын хоорондын холбоо харилцааны систем

9.8.2 Бэлтгэл сургуулилт, тэмцээний үеэр ноцтой осол гарсан тохиолдолд бэртэж гэмтсэн хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх замаар шаардлагатай эмнэлгийн тусламж үзүүлэх журамтай байх ёстой. Тамирчид, дасгалжуулагчид, спортын үйл ажиллагаанд оролцож байгаа бусад хүмүүст эдгээр журмын талаар мэдэгдэж, шаардлагатай сургалтанд хамруулна.

9.8.3 Аюулгүй байдлын дүрэм журмыг сайжруулж, хойшид гарах эрсдлийг бууруулахын тулд бэлтгэл сургуулилт, тэмцээний үеэр гарсан гэмтэл ослын талаарх мэдээллийг цуглуулах суваг байх ёстой.



Гэмтэл осолтой холбоотой мэдээллийг холбогдох хүмүүсийн зөвшөөрлөөр цуглуулж, нууцлалыг хадгалж, судалгааны хүлээн зөвшөөрөгдсөн аргаар, ёс зүйн хэм хэмжээг баримтлан судалж ажиллана.

## 10. ТЭМЦЭЭНИЙ БАЙГУУЛАМЖ

### 10.1 Ерөнхий

Усан спортын тэмцээн болон сургалт явуулах байгууламж, усан сан нь тамирчдыг сургах, ур чадвараа сайжруулах, бүрэн хүч чадлаа гаргах боломжтой, боломжит хамгийн сайн орчинг бүрдүүлсэн байна. Энэхүү шаардлага нь олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохицуулах зорилго бөгөөд олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд хяналт тавих нь тухайн байгууламжийн өмчлөгч буюу хянагчийн үүрэг байна.

### 10.2 Усан сан

2.2.1 Бүх улсын аварга шалгаруулах тэмцээнийг Дэлхий усан спортын холбоо (World Aquatics)-ны наад захын шаардлагыг хангасан усан санд явуулах ёстой

2.2.2 МУССХ-ны бусад тэмцээн, арга хэмжээг Дэлхий усан спортын холбоо (World Aquatics)-ны наад захын шаардлагыг хангасан усан санд явуулах ёстой боловч Удирдах зөвлөл тэмцээний үр дүн, тамирчдын аюулгүй байдалд нөдөөлөхгүй гэж үзвэл усан сангийн зарим стандартаас татгалзаж болно.

### 10.3 Автомат төхөөрөмж

МУССХ-ны тэмцээнүүдийн шүүлтэнд Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны хүлээн зөвшөөрсөн автомат цаг болон удирлагын төхөөрөмж, тэр дундаа видео шүүлтийн төхөөрөмжийг ашиглахыг эрмэлзэнэ.

### 10.4 Усан сан, байгууламжийн бэлэн байдал

МУССХ-ны бүх төрлийн тэмцээнийг зохион байгуулах байгууламж нь тэмцээний нээлт болохоос дор хаяж нэг (1) хоногийн өмнө тэмцээний бэлтгэлийг хангахад зориулан ашиглах боломжтой болсон байх ёстой. Мөн бүх усан сангууд тэмцээн эхлэхээс өмнө дор хаяж гурав (3) хоногийн өмнөөс оролцогчдод ашиглах боломжтой байх ёстой.

#### 10.4.1 Сургалт

Тэмцээний өдрүүдэд тэмцээн явагдаагүй үед усан сангууд бэлтгэл хийх боломжтой байна.

10.5 Байгууламжийн зай талбайн боломжоос шалтгаалан бэлтгэл, тэмцээнийг зохих ёсоор ажиглах боломжтой суудлыг дасгалжуулагчид болон багийн албан тушаалтнуудад зориулан бэлтгэхийг эрмэлзэнэ.



10.6 Тэмцээнд ашиглах шинэ тоног төхөөрөмж (жишээ нь, гарааны тавцан, эгнээний олс гэх мэт) –ийг тэмцээн эхлэхээс дор хаяж 1 сарын өмнө тамирчдад танилцуулж, ашиглаж дадлагажих боломжоор хангах ёстой.

10.7 Усан сэлэлтийн тэмцээний гарааны үеэр гарсан техникийн доголдол болон тоног төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд Ерөнхий шүүгч тухайн гараанд гарсан бүх оролцогчдод дахин гараанд гарах боломжийг олгоно.

10.8 Тэмцээн зохион байгуулагдах усан сангийн байгууламжийг эзэмшигч эсвэл эзэн нь тамирчид, тамирчдын туслан дэмжигчид болон хөгжөөн дэмжигчдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох хууль тогтоомж, эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон шаардлагыг дагаж мөрдөх ёстой.

## **11. ШҮҮГЧДИЙН БАГ**

### **11.1 Ерөнхий зүйл**

Шүүгчдийн баг гэдэгт тухайн тэмцээний үйл ажиллагааг шүүн явуулах Ерөнхий шүүгч, бусад бүх шүүгчид, техникийн өрөөний шүүгчдийг хамааруулан ойлгоно. Тэмцээний шүүгчид нь шүүгчийн сургалтанд хамрагдаж, зохих түвшний эрхийн гэрчилгээтэй байх ёстой. (МУССХ-ны Шүүгчдийн сургалт болон Дэлхийн усны холбооны шүүгчийн сургалтанд хамрагдсныг ойлгоно).

Тэмцээний Ерөнхий шүүгч болон шүүгчдийн бүрэлдэхүүнийг МУССХ-ны Шүүгчдийн зөвлөл санал болгож Удирдах зөвлөл эсвэл ЕНБД батална. Шүүгчдийн багт багтсан шүүгч тэмцээнийг шүүхээс гэнэт татгалзсан, хүндэтгэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол 200,000 төгрөгөөр торгох шийтгэл оноож ёс зүйн асуудлаар хариуцлага тооцуулахаар ёс зүйн зөвлөлд мэдэгдэл хүргүүлнэ.

### **11.2 Нас**

МУССХ-ны тэмцээний шүүгчдийн багийн гишүүдийн насны дээд хязгаар жаран (60) нас байна.

### **11.3 Шүүгчдийн бүрэлдэхүүний гишүүнчлэл**

МУССХ-ны тэмцээний үйл ажиллагааг шүүн явуулах шүүгчдийн багийн гишүүд нь Шүүгчдийн зөвлөлийн гишүүн байх ёстой.

## **12. ЦОМ, МЕДАЛЬ, ОНОО**

12.1 МУССХ-ны усан сэлэлтийн тэмцээний оноо, шагналыг дараах байдлаар олгоно.

### **12.2 Меадль, диплом**

Ганцаарчилсан болон буухиа уралдааны эхний гурван байранд орсон баг/тамирчдад Алт, Мөнгө, Хүрэл медаль, диплом олгоно. Буухиа тэмцээний Усан сэлэлтийн буухиа уралдааны урьдчилсан болон



финалын гарааны багийн бүрэлдэхүүн өөр байвал медалийг аль багийн бүрэлдэхүүнд олгохыг тухайн байгууллага клубын багийн ахлагч шийднэ.

Тамирчид ижил цагийн амжилт үзүүлсэн бол медалийг доорхи байдлаар олгоно.

- Нэг дүгээр байрны тамирчдын цаг ижил бол: 2 Алт, Мөнгө байхгүй, 1 Хүрэл
- Хоёр дугаар байрны тамирчдын цаг ижил бол: 1 Алт, 2 Мөнгө, Хүрэл байхгүй
- Гурав дугаар байрны тамирчдын цаг ижил бол: 1 Алт, 1 Мөнгө, 2 Хүрэл

Хэрэв гурван тамирчин ижил цагийн амжилт гаргасан бол медалийг доорхи байдлаар олгоно

- Нэг дүгээр байрны тамирчдын цаг ижил бол: 3 Алт, Мөнгө байхгүй, Хүрэл байхгүй
- Хоёр дугаар байрны тамирчдын цаг ижил бол: 1 Алт, 3 Мөнгө, Хүрэл байхгүй
- Гурав дугаар байрны тамирчдын цаг ижил бол: 1 Алт, 1 Мөнгө, 3 Хүрэл

### 12.3 Багийн Цом

МУССХ-ны Ерөнхийлөгчийн нэрэмжит тэмцээн болон клубуудын цомын тэмцээнийг багийн шилжин явах цомтой зохион байгуулна. Усан спортын багийн цомыг дараах онооны системээр үнэлэж, хамгийн өндөр оноо авсан багт олгоно.

Хувийн гараа:	Байр 1-6:	12, 10, 8, 6, 4, 2 оноо
Багийн буухиа	Байр 1-6:	24, 20, 16, 12, 8, 4 оноо

### 12.4 Ганцаарчилсан тамирчны Цом

МУССХ-ны Ерөнхийлөгчийн нэрэмжит тэмцээнийг ганцаарчилсан тамирчны цомтой зохион байгуулна. Цомыг тамирчинд үүрд хадгалуулна. Усан спортын ганцаарчилсан тамирчны цомыг дараах онооны системээр үнэлэж, хамгийн өндөр оноо авсан эрэгтэй, эмэгтэй тамирчинд олгоно.

1-р байр	5 оноо
2-р байр	3 оноо
3-р байр	2 оноо
4-р байр	1 оноо
Улсын рекорд амжилт	2 оноо

Хэрэв оноо тэнцсэн бол Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны онооны системийг ашиглах бөгөөд шийдвэрийг зохион байгуулах хороо гаргана.





### 13. ЭСЭРГҮҮЦЭЛ БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ

#### 13.1 ЭСЭРГҮҮЦЭЛ

13.1.1 Эсэргүүцлийг доорхи тохиолдолд гаргаж болно.

- а. Тэмцээний дүрэм, зохион байгуулах журам тодорхой биш
- б. Тэмцээн зохион байгуулагдах нөхцөл нь тамирчдад эрсдэлтэй
- в. Шүүгчийн шийдвэрийг эсэргүүцэж болно. Гэвч баримтад тулгуурласан шийдвэрийг эсэргүүцэхийг хориглоно.

13.1.2 Эсэргүүцэл мэдүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- а. Ерөнхий шүүгчид мэдүүлэх
- б. Холбооноос боловсруулсан маягтан дээр эсэргүүцлийг бичсэн байх
- в. Багийн ахлагч мэдүүлгийг бөглөх
- г. 50,000 төгрөгийн хураамж төлсөн байх
- д. Тухайн уралдаан болсоноос хойш 30 минутын дотор  
Дүрмийн дагуу мэдүүлсэн эсэргүүцлийг дараагийн үйл ажиллагаа болон тэмцээний гараа эхлэхээс өмнө шийдвэрлэнэ.

13.1.3 Бүх эсэргүүцлийг Ерөнхий шүүгч хянаж шийдвэрлэнэ. Ерөнхий шүүгч эсэргүүцлийг хүлээж авахгүй байх шийдвэр гаргасан бол шалтгааныг тайлбарлах үүрэгтэй. Багийн ахлагч Ерөнхий шүүгчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол давж заалдах шатны шүүгчид давж заалдах эрхтэй. Давж заалдах шатны шүүгчдийн багийн гаргасан шийдвэр нь эцсийн шийдвэр байна.

13.1.4 Эсэргүүцлийг хүлээж авахгүй байх шийдвэр гарсан бол 11.1.2 заасан хураамжийг тэмцээн зохион байгуулагчид шилжүүлнэ. Эсэргүүцлийг хүлээн авсан бол хураамжийг буцааж олгоно.

#### 13.2 ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮГЧДИЙН БАГ

13.2.1 Насанд хүрэгчдийн болон Өсвөр үе, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээний үед давж заалдах шатны шүүгчийн багийг тухайн тэмцээнд оролцож байгаа Удирдах зөвлөлийн гишүүдээс бүрдүүлж Ерөнхийлөгч эсвэл дэд Ерөнхийлөгч даргална. Бусад тэмцээний үед тухайн тэмцээнд оролцож байгаа Удирдах зөвлөлийн гишүүд болон шүүгчдийн зөвлөлийн гишүүдээс бүрдүүлэх бөгөөд ЕНБД багийг даргална. Давж заалдах шатны шүүгчийн багийн гишүүн тус бүр нэг саналын эрхтэй байх ба санал тэнцсэн тохиолдолд даргын шийдвэрээр эцэслэнэ.

13.2.2 Давж заалдах шатны шүүгчдийн багийн гишүүн нь тухайн гомдол эсэргүүцлийн асуудалтай сонирхлын зөрчилтэй бол санал өгөх эрхгүйгээр оролцоно.



Мөн эсэргүүцэл гаргасан тухайн шийдвэрийг гаргасан шүүгч санал өгөх эрхгүй оролцоно. Яаралтай нөхцөлд Шүүгчдийн багийн бүх гишүүдийг цуглуулах боломжгүй бол ирсэн болон цахимаар оролцсон гишүүдээс санал хураан шийдвэр гаргана. Тухайн шийдвэр эцсийн шийдвэр байна.



## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. УСАНД СЭЛЭЛТИЙН ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ**

1. ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
2. АЛБАН ТУШААЛТНУУД
3. ХАГАС ШИГШЭЭ БОЛОН ШИГШЭЭ УРАЛДААНЫ ГАРААНЫ ХУВААРЬЛАЛТ
4. ГАРАА
5. ӨВРӨӨР ДАЛЛАХ СЭЛЭЛТ
6. АРААР ДАЛЛАХ СЭЛЭЛТ
7. МЭЛХИЙ СЭЛЭЛТ
8. ДАЛАЙН ГАХАЙ (ЭРВЭЭХИЙ) СЭЛЭЛТ
9. ХОЛИМОГ СЭЛЭЛТ
10. УРАЛДААН
11. ХУГАЦАА
12. УЛСЫН ДЭЭД АМЖИЛТ (РЕКОРД)
13. АВТОМАТ ЦАГИЙН ТӨХӨРӨӨМЖИЙГ АШИГЛАХ ЖУРАМ
14. НАСНЫ АНГИЛАЛ
15. УСНЫ ХУВЦАС ХЭРЭГСЭЛ
16. УСАН САНГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ



## 1. ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1. Удирдах зөвлөлөөс томилогдсон тэмцээн зохион байгуулах хороо нь усанд сэлэлтийн тэмцээнийг зохион байгуулахад шаардлагатай, холбооны дүрэм журмаар зохицуулагдаагүй асуудлуудыг хариуцан ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд тэмцээнийг хойшлуулах эрхтэй.

1.2 Тэмцээн зохион байгуулах хороо нь тэмцээнийг шударга, ёс зүйтэй зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор хангалттай тооны албан хаагчдыг томилон ажиллуулна.

1.2.1 Холбооны бүх тэмцээнүүдийн зохион байгуулах хороог тус тусад нь Удирдах зөвлөлийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг батална.

1.2.2 Автомат цагийн төхөөрөмж байхгүй тохиолдолд Цагийн Ерөнхий /АХЛАХ ЦАГЧИН/ шүүгчийг томилон ажиллуулна. Усан сангийн зам бүрт хамгийн багадаа нэг (1) цагийн шүүгч байхаар зохицуулалт хийнэ. Боломжтой бол зам бүрт гурван (3) цагийн шүүгч байх нь хамгийн тохиромжтой гэж үзнэ.

1.2.3 Автомат цагны төхөөрөмж болон цагийн шүүгчгүй тохиолдолд Барианы шүүгчийг ажиллуулна.

1.3 Тэмцээн зохион байгуулах хороо нь тэмцээний өмнө усан сан болон техник, тоног төхөөрөмжийг заавал нягтлан үзэж стандартын шаардлага болон бүрэн бүтэн байдал, ажиллагааны доголдол байгаа эсэхийг шалгасан байна.

1.4 Усан сан дотор видео төхөөрөмжийг ашиглаж байгаа тохиолдолд уг төхөөрөмжийг алсын удирдлагаар удирдах бөгөөд энэ нь тамирчдын үзэгдэх орчинг хязгаарлах, усан сангийн хийцлэлд ямар нэгэн өөрчлөлт оруулахааргүй байна.

1.5 Зохион байгуулах хороо нь тамирчдад Call room-ээс гарахаас өмнө заавал мөрдөх шаардлагатай тамирчдын танилцуулга, уралдаанд бэлтгэх дүрэм журам болон урьдчилсан, хагас финал, финалын гарааны замын хуваарийг танилцуулах үүрэгтэй.

1.6. МУССХ-ны Усанд сэлэлтийн тэмцээний хөтөлбөр

### 1.6.1 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн (25м)

	Эрэгтэй	Эмэгтэй
Өврөөр даллах сэлэлт	50м, 100м, 200м 400м, 800м, 1500м	50м, 100м, 200м 400м, 800м, 1500м
Араар даллах сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м
Мэлхий сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м
Далай гахай сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м



Холимог сэлэлт	100м, 200м, 400м	100м, 200м, 400м
Буухиа (өврөөр даллах)	4х 50м, 4х 100м, 4х 200м	4х 50м, 4х 100м, 4х 200м
Буухиа (холимог сэлэлт)	4х 50м, 4 х 100м	4х 50м, 4 х 100м
Холимог буухиа	4 х 50м (өврөөр даллах сэлэлт), 4 х 50м (холимог сэлэлт)	

### 1.6.2 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн (50м)

	Эрэгтэй	Эмэгтэй
Өврөөр даллах сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м
	400м, 800м, 1500м	400м, 800м, 1500м
Араар даллах сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м
Мэлхий сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м
Далай гахай сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м
Холимог сэлэлт	200м, 400м	200м, 400м
Буухиа (өврөөр даллах)	4х 100м, 4х 200м	4х 100м, 4х 200м
Буухиа (холимог сэлэлт)	4 х 100м	4х 100м
Холимог буухиа	4 х 100м (өврөөр даллах сэлэлт), 4 х 100м (холимог сэлэлт)	

### 1.6.3 Өсвөр үе, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн (25м)

	Эрэгтэй	Эмэгтэй
Өврөөр даллах сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м
	400м, 800м, 1500м	400м, 800м, 1500м
Араар даллах сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м
Мэлхий сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м
Далай гахай сэлэлт	50м, 100м, 200м	50м, 100м, 200м
Холимог сэлэлт	200м, 400м	200м, 400м
Холимог буухиа	4 х 50м (өврөөр даллах сэлэлт), 4 х 50м (холимог сэлэлт) 4 х 100м (өврөөр даллах сэлэлт), 4 х 100м (холимог сэлэлт)	

### 1.6.4 Ерөнхийлөгчийн цом болон бусад тэмцээн

МУССХ-ны Ерөнхийлөгчийн цом, клубуудын нэрэмжит тэмцээн болон бусад тэмцээнүүдийн хөтөлбөрийг тухай бүрт нь зохион байгуулах хороо шийдвэрлэж байна.



## 2. ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

### 2.1 Ерөнхий шүүгч

2.1.1 Ерөнхий шүүгч нь тэмцээн зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг бүрэн удирдлагаар хангаж тус бүрийнх нь үүрэг хариуцлагыг тодорхойлж, тэмцээний дүрэм журмын талаархи зааварчилгааг өгч ажиллана. Ерөнхий шүүгч нь МУССХ-ны дүрэм болон бусад шийдвэрүүдийг мөрдөн ажиллах бөгөөд дүрмээр зохицуулагдаагүй тэмцээн зохион байгуулахтай холбогдон гарах бүх уулзалт, арга хэмжээ, тэмцээнийг бодитоор зохион байгуулах явцад гарах бүх асуудлыг хариуцан шийдвэрлэнэ.

2.1.2 Ерөнхий шүүгч нь холбооны дүрэм журмын хэрэгжилтийг хангахын тулд тэмцээний аль ч үе шатанд хөндлөнгөөс оролцож болох бөгөөд тэмцээний үед гарах бүх гомдол эсэргүүцлийг хянан шийдвэрлэнэ.

2.1.3 Цагийн шүүгчгүй тохиолдолд барианы шүүгчийг хаана ямар байрлалд ажиллахыг Ерөнхий шүүгч тогтооно. Автомат цагийн төхөөрөмж ашиглаж байгаа бол энэ дүрмийн Хоёрдугаар бүлгийн 13 зүйлд заасны дагуу зөвөлгөөг өгч ажиллана.

2.1.4. Ерөнхий шүүгч нь тэмцээний үеэр зохион байгуулагчдыг үүрэг хариуцлагынхаа хүрээнд байх ёстой байрлалдаа, үүрэгт ажлаа гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавина. Ерөнхий шүүгч нь байхгүй байгаа болон ажиллах чадваргүй гэж үзсэн хүнийг сольж өөр хүн томилон ажиллуулж болно. Шаардлагатай тохиолдолд зохион байгуулагчдын бүрэлдэхүүнд нэмэлтээр хүн авч ажиллуулж болно.

2.1.5 Гараанд гарч байгаа тамирчин тэмцээний хувцас хэрэглэлээс бусад хувцсаа тайлсны дараа Ерөнхий шүүгч нь богино давтамжтай үргэлжлэх шүглийн дохиогоор гараа эхлэхэд бэлэн болсныг мэдэгдэнэ. Дараа нь урт үргэлжлэх шүглийн дохиогоор тамирчдыг гарааны тавцан дээр (араар даллах сэлэлт болон холимог буухианы тамирчид тэр даруй ус руу орно) байрлалаа эзлэхийг мэдэгдэнэ. Араар даллах сэлэлт болон холимог буухианы гарааны хувьд хоёр дахь урт үргэлжлэх шүглийн дохиогоор тамирчид гараа эхлэх байрлалд орно. Тамирчид болон зохион байгуулагчид гараа эхлэхэд бэлэн болмогц Ерөнхий шүүгч нэг гараа алдлан барьж гарааны шүүгчид гарааг цааш удирдан явуулахыг мэдэгдэнэ. Алдлан барьсан гарыг гараа эхлэх хүртэл энэ байрлалд нь байлгана.

2.1.6 Гарааны шүүгч болон Ерөнхий шүүгч хоёулаа ажиглаж, шийдвэр гаргасан тохиолдолд гараа эхлэхээс өмнө сэлэгчийн гарааг хүчингүй болгоно. Автомат цагийн төхөөрөмжийг мөн гарааг хүчингүй болгосон шийдвэрийг баталгаажуулахад ашиглаж болно.



2.1.7 Ерөнхий шүүгч ямар ч сэлэгчийн дүрмийн бус зөрчил гаргасныг өөрийн биеэр ажигласан бол түүний гарааг хүчингүйд тооцож болно. Мөн Ерөнхий шүүгч нь бусад зохион байгуулагчдын мэдээллийн дагуу сэлэгчийг дүрмийн бус зөрчлийнх нь төлөө тэмцээнээс хасч болно. Тэмцээнээс хасах болон гарааг нь хүчингүй болгох тухай бүх шийдвэрийг зөвхөн Ерөнхий шүүгч гаргана.

2.1.8 Бүх болзошгүй зөрчлийн талаар Ерөнхий шүүгчид амаар мэдэгдэнэ. Ерөнхий шүүгч баталгаажуулсны дараа зөрчлийн мэдээллийг амаар өгсөн шүүгч тэмцээнээс хассан эсвэл гарааг хүчингүй болгосон тухай картанд зөрчлийн тэмдэглэлийг (сэлэгчийн нэр, төрөл, зам болон зөрчлийн талаар) хөтлөн гарын үсэг зурж баталгаажуулна.

2.1.9 Ерөнхий шүүгч нь буухиа сэлэлтийн гарааны үед буухиа дамжуулагч сэлэгчийг барианы хананд бүрэн хүрсэн үед буухиа хүлээн авагч гарааны тавцангаас үсэрсэн эсэхийг хянах шүүгчийг мөн томилон ажиллуулна.

## 2.2 Хяналтын өрөөний ажилтан

2.2.1 Хяналтын өрөөний ажилтан нь автомат цагны төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавина.

2.2.2 Хяналтын өрөөний ажилтан нь компьютерийн хэвлэмэл материалаас гарсан үр дүнг шалгах үүрэгтэй.

2.2.3 Хяналтын өрөөний ажилтан нь нь буухиа солилцооны дарааллыг хянаж, түрүүлж үсэрсэн талаархи зөрчлийг Ерөнхий шүүгчид мэдээлэх үүрэгтэй.

2.2.4 Хяналтын өрөөний ажилтан нь түрүүлж үсэрсэн зөрчлийг баталгаажуулахын тулд видео цагийг хянаж болно.

2.2.5 Хяналтын өрөөний ажилтан нь:

- Урьдчилсан гараа болон хагас финалын гарааны дараахи үр дүнд хяналт тавина
- Үр дүнг албан ёсны хуудсанд бичих
- Шинээр тогтоосон рекорд амжилтыг бүртгэх
- Шаардлагатай тохиолдолд онооны үнэлгээг гаргаж өгөх үүрэгтэй

## 2.3 Гарааны шүүгч

2.3.1 Ерөнхий шүүгч гарааг цааш удирдан явуулах эрхийг Гарааны шүүгчид шилжүүлсэн (2.1.5) мөчөөс гараа эхлэх хүртэл тамирчдыг Гарааны шүүгч удирдана. Гарааг 4 дүгээр зүйлд заасны дагуу удирдан эхлүүлнэ.

2.3.2 Гарааны шүүгч нь гарааг саатуулсан, зааврыг зориудаар зөрчсөн болон бусад зөрчил гаргасан тамирчны талаар Ерөнхий шүүгчид мэдэгдэнэ. Энэхүү зөрчлийнх нь төлөө тухайн тамирчны гарааг хүчингүй болгох шийдвэрийг зөвхөн Ерөнхий шүүгч гаргаж болно.



2.3.3 Гарааны шүүгч гараа хүчинтэй, шударга явагдсан талаархи шийдвэр гаргах эрхтэй боловч эцсийн шийдвэрийг зөвхөн Ерөнхий шүүгч гаргана.

2.3.4 Гарааны шүүгч нь гараа эхлэх үед усан сангийн хажуу талд, гараа эхлэх талын булангаас ойролцоогоор таван метрийн зайд, цагийн шүүгчид гараа эхлүүлэх дохиог харах эсвэл сонсох боломжтой, тамирчин дохионы дууг сонсох боломжтой газарт байрлалаа эзэлнэ.

2.3.5 Гарааны шүүгч өөрийн эрх мэдлийн хүрээнд илэрсэн аливаа зөрчлийг Ерөнхий шүүгчид мэдээлнэ.

#### 2.4 Call Room-ын зохицуулагч

2.4.1 Call room-ын зохицуулагч нь тэмцээний гараа бүрийн өмнө тамирчдыг цуглуулж, гараанд бэлэн болгоно.

2.4.2 1 Call room-ын зохицуулагч нь дараахи зөрчлийн талаар Ерөнхий шүүгчид мэдээлнэ.

- Усны хувцасны зөрчил
- Зар сурталчилгааны журам зөрчих
- Гарааг зарлах үед тамирчин Call room-д байхгүй байсан

#### 2.5 Эргэлтийн Ахлах шүүгч

2.5.1 Эргэлтийн Ахлах шүүгч нь уралдааны үеэр эргэлтийн шүүгч нар үүргээ бүрэн гүйцэд биелүүлж байгаа эсэхэд хяналт тавина.

#### 2.6 Эргэлтийн шүүгч

2.6.1 Усан сангийн зам бүрийн төгсгөлд нэг эргэлтийн шүүгч байрлаж, гараа эхлэхээс дуусах хүртэл болон эргэлт бүр дээр тамирчин ямар нэг дүрмийн алдаа гаргаж байгаа эсэхэд хяналт тавина.

2.6.2 Гарааны эргэлтийн шүүгчийн шүүлт нь гараа эхлэх дохионоос эхлэж сэлэгч гарын эхний таталтаа хийж дуусах хүртэл үргэлжилнэ. Харин мэлхий сэлэлтийн төрөлд сэлэгч гарын хоёр дахь таталтаа хийж дуусгах хүртэл үргэлжилнэ.

2.6.3 Эргэлт бүр дээр эргэлтийн шүүгчийн шүүлт нь сэлэгчийн хананд хүрэхийн өмнөх сүүлчийн гарын таталтаас эхэлж, эргэлт хийсний дараахи эхний гарын таталт дуусах хүртэл үргэлжилнэ. Харин мэлхий сэлэлтийн төрөлд эргэлт хийсний дараа сэлэгч гарын хоёр дахь таталтаа хийж дуусгах хүртэл үргэлжилнэ.

2.6.4 Барианы эргэлтийн шүүгчийн шүүлт нь сэлэгчийн хананд хүрэхээс өмнөх сүүлчийн гарын таталтаас эхэлнэ.

2.6.5 Араар даллах сэлэлтийн гараанд хөлийн ивүүр ашиглаж байгаа бол гарааны эргэлтийн шүүгч ивүүрийг суурьлуулж мөн хурааж авна. Ивүүрийг суурьлуулахдаа Тэг (0) заалт дээр тохируулсан байна.





2.6.6 Ганцаарчилсан 800 ба 1500 метрийн зайн уралдааны үед, эргэлтийн шүүгч нь замын төгсгөлийн эргэлт бүрт тамирчны сэлсэн тойргийн тоог тэмдэглэнэ. Мөн замын төгсгөлийн эргэлт бүрт, сондгой тоо бүхий "тойргийн карт"-ыг харуулах замаар үлдсэн тойргийн тоог тамирчинд мэдэгдэнэ. Усан доорх дэлгэц гэх мэт электрон төхөөрөмжийг ашиглаж болно.

2.6.7 Ганцаарчилсан 800 ба 1500 метрийн зайн уралдааны үед эргэлтийн шүүгч нь зай дуусахад 100м + 5м дутуу байх үед анхааруулах дохио өгнө. Анхааруулах дохиог тамирчин эргэлтээ хийснээс хойш замын 5 метрийн тэмдэг хүртэл дахин үргэлжлүүлэн өгч болно. Анхааруулах дохиог шүглээр эсвэл хонхоор өгч болно.

2.6.8 Буухиа уралдааны үед эргэлтийн шүүгч нь буухиа шилжүүлэгч тамирчин барианы хананд хүрэх үед буухиа хүлээн авагч тамирчны хөл гарааны тавцангаас салаагүй байгаа эсэхийг хянана. Буухиа уралдааны шилжилтийг хянах автомат төхөөрөмж байгаа тохиолдолд 13.1 зүйлийг баримтлан ашиглана.

2.6.9 Эргэлтийн шүүгчид эрх мэдлийн хүрээнд илэрсэн аливаа зөрчлийг Ерөнхий шүүгчид мэдээлнэ.

## 2.7 Хажуугийн Хяналтын шүүгчид

2.7.1 Хажуугийн Хяналтын шүүгчид усан сангийн хоёр талд байрлана.

2.7.2 Хажуугийн Хяналтын шүүгч бүр тухайн сэлэлтийн төрөлд хамаарах сэлэлтийн техникийн загварчлалыг тамирчин дүрмийн дагуу зөв гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавина. Мөн эргэлт болон барианы үйл явцад хяналт тавьж, эргэлтийн шүүгчдэд туслах ёстой.

2.7.3 Хажуугийн Хяналтын шүүгч нь өөрийн хяналтын чиг үүрэгт хамааралтай аливаа зөрчлийг Ерөнхий шүүгчид тайлагнана.

## 2.8 Ахлах цагийн шүүгч

2.8.1 Ахлах цагийн шүүгч нь бүх цагийн шүүгчдийн байрлал болон тэдгээрийн хариуцах замыг тогтооно. Нэг замд гурван (3) цагийн шүүгч байх нь хамгийн тохиромжтой. Автомат цагийн төхөөрөмжийг ашиглаагүй тохиолдолд хоёр (2) нэмэлт цагийн шүүгчийг томилох бөгөөд тэдгээр нь аль нэг цагийн шүүгчийн цаганд доголдол үүсвэл орлох үүрэгтэй байна.

2.8.2 Нэг заманд зөвхөн нэг (1) цагийн шүүгч байгаа бол цаганд доголдол гарсан тохиолдолд орлох нэмэлт цагийн шүүгчийг томилно. Мөн ахлах цагийн шүүгч нь уралдаан бүрийн ялагчийн цагийг бүртгэж авна.

2.8.3 Ахлах цагийн шүүгч нь зам бүрийн цагийн шүүгчдийн цагийн бүртгэлийн картыг авч үзэх



бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдний цагийг шалгана.

2.8.4 Ахлах цагийн шүүгч нь зам тус бүрийн албан ёсны цагийг шалгаж картанд тэмдэглэж авна.

## 2.9 Цагийн шүүгчид

2.9.1 Цагийн шүүгч бүр 11.3-т заасны дагуу өөрт олгосон замын тамирчдын цагийг авна.

2.9.2 Цагийн шүүгч бүр гарааны дохиогоор цагаа эхлүүлэх бөгөөд хариуцан ажиллаж буй замын тамирчин барианы хананд хүрэх мөчид цагийг зогсооно. Цагийн шүүгч нь ахлах цагийн шүүгчийн даалгавраар 100 метрээс дээш зайд эргэлтийн тойргийн цагийг бүртгэж болно

2.9.3 Уралдаан дуусмагц зам тус бүрийн цагийн шүүгчид тамирчны цагийг картанд тэмдэглэж, ахлах цагийн шүүгчид өгөх ба түүний хүссэнээр цагаа шалгуулна. Ерөнхий шүүгч богино үргэлжлэх шүглийн дохиог өгч дараагийн гараа эхлэхэд бэлэн болсныг мэдэгдэх үед л өмнөх уралдааны цагийг тэглэж дараагийн гарааны цагийг авахад бэлдэнэ.

2.9.4 Автомат цагийн төхөөрөмж ашиглаж байсан ч цагийн шүүгчдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь ашиглах шаардлагатай байж болно.

## 2.10 Барианы шүүгч - шаардлагатай тохиолдолд

2.10.1 Барианы шүүгчид барианы шугмыг үргэлж тодорхой харж байх боломжтой байрлалд байрлана.

2.10.2 Уралдаан бүрийн дараа барианы шүүгчид тэдэнд өгсөн үүргийн дагуу тамирчдын эзэлсэн байрыг тодруулж, тайлагнана. Барианы шүүгч нь товчлуур дарах үүргээс бусдаар цагийн шүүгчийн ажлыг давхар хийж болохгүй.

## 2.11 Ахлах бүртгэгч

2.11.1 Ахлах бүртгэгч нь компьютерээс хэвлэгдэн гарсан үр дүн болон Ерөнхий шүүгчээс хүлээн авсан цагийн үзүүлэлт болон амжилтын талаархи мэдээллийг нягтлан хянах үүрэгтэй.

## 2.12 Бүртгэгч

2.12.1 Бүртгэгч нь урьдчилсан болон хагас финалын гараануудын дараа хасагдсан сэлэгчдийн үзүүлсэн амжилтыг хянаж үр дүнг албан ёсны маягтад оруулах, шинэ рекорд амжилтыг бүртгэх, холбогдох оноог тооцох зэрэг үүргийг хүлээнэ.

## 2.13 Видео хяналтын ахлах шүүгч

2.13.1 Видео хяналтын шүүгч нь тэмцээний үеэр видео хяналтын шүүгчдийг тус тусын ямар албан тушаалд ажиллаж, үүргээ биелүүлэхийг баталгаажуулна.

2.13.2 Видео хяналтын ахлах шүүгч нь видео хяналтын шүүгчдийн мэдүүлсэн бүх дүрмийн зөрчлийг хянаж баталгаажуулна.

2.13.3 Видео хяналтын ахлах шүүгч нь Ерөнхий шүүгчийн хүсэлтээр өөрт нь мэдээлсэн бүх



дүрмийн зөрчлийг хянаж баталгаажуулна.

2.13.4 Видео хяналтын ахлах шүүгч нь видео хянан үзэх явцад батлагдсан аливаа зөрчлийг Ерөнхий шүүгчид мэдээлнэ.

#### 2.14 Видео хяналтын шүүгч

2.14.1 Видео хяналтын шүүгч нь тухайн усанд сэлэлтийн төрөл, сэлэлтийн хэв маягтай холбоотой зөрчлийг хянаж, эргэлт болон бариаг ажиглана.

2.14.2 Видео хяналтын шүүгч илэрсэн аливаа зөрчлийг видео хяналтын ахлах шүүгчид мэдэгдэнэ. Хэрэв зөрчил нь батлагдсан бол видео хяналтын шүүгч хасагдах картыг бөглөнө.

#### 2.15 Шүүгчдийн шийдвэр

2.15.1 Шүүгчид шийдвэрээ Хоёрдугаар бүлэгт өөрөөр заагаагүй бол бие даан, бие биенээсээ хамааралгүйгээр гаргана.

### **3. УРЬДЧИЛСАН, ХАГАС ШИГШЭЭ, ШИГШЭЭ УРАЛДААНЫ БАЙРЛАЛ**

МУССХ-ны бүх тэмцээнүүдэд тамирчдын гарааны байрлалыг доорхи байдлаар хуваарьлана.

#### 3.1 Урьдчилсан гараа

3.1.1 Тамирчид тогтоосон хугацаанд тэмцээнд өрсөлдөх төрөл, зайн мэдүүлгээ гаргах ёстой бөгөөд мэдүүлэгт тэмдэглэсэн цагийг үндэслэн тэднийг эрэмбэлнэ. Албан ёсны цагийн үзүүлэлт мэдүүлээгүй тамирчдыг хамгийн муу цагтай гэж үзэн жагсаалтын төгсгөлд цаггүй эрэмбэлнэ. Ижил цагийн үзүүлэлттэй тамирчид болон албан ёсны цагийн үзүүлэлтгүй тамирчид нэгээс (1) олон байвал эрэмбийг сугалаагаар шийдвэрлэнэ. Тамирчдын мэдүүлсэн цагийн үзүүлэлтийг нь харгалзан гарааны байрлалыг нь 3.1.2 – т заасан зарчмыг баримтлан доорхи аргаар тогтооно.

3.1.1.1 Тухайн төрөл зайд зөвхөн нэг урьдчилсан гараа байвал шигшээ уралдааны зарчмыг баримтлан замыг хуваарьлах бөгөөд шигшээ уралдааны үеэр л уралдана.

3.1.1.2 Хэрэв тухайн төрөл зайд хоёр (2) урьдчилсан гараа байвал хамгийн сайн цагийн үзүүлэлттэй тамирчин хоёр дахь гараанд, дараагийн тамирчин нэг дэх гараанд, дараагийн тамирчин хоёр дахь гараанд гэдэг зарчмаар гарааг хуваарьлана.

3.1.1.3 400м, 800м, 1500м зайн уралдаанаас бусад төрөл зайд гурван урьдчилсан гараа гарахаар байвал хамгийн сайн цагийн үзүүлэлттэй тамирчин гурав дахь гараанд, дараагийн тамирчин хоёр дахь гараанд, гурав дахь сайн цагийн үзүүлэлттэй тамирчин нэг дэх гараанд, дөрөв дэх тамирчин гурав дахь гараа, тав дахь тамирчин хоёр дахь, зургаа дахь тамирчин эхний гараанд гэх мэт зарчмаар гарааг хуваарьлана.



3.1.1.4 400м, 800м, 1500м зайн уралдаанаас бусад төрөл зайд дөрөв болон түүнээс олон урьдчилсан гараа гарахаар байвал сүүлийн гурван гараа 3.1.1.3- д заасан зарчмаар хуваарьлагдах бол сүүлээсээ дөрөв дэх гарааг үлдсэн тамирчдын хамгийн сайн цагтай тамирчдаар, дараагийн гарааг сүүлийн дөрвөн гараанд багтаагүй хамгийн сайн цагийн үзүүлэлттэй тамирчдаар бүрдүүлэх гэх мэт зарчмаар цааш гарааг хуваарьлана. Гараа бүрийн байрлалыг мэдүүлсэн цагийн эрэмбээр, 3.1.2-т заасан зарчмын дагуу тогтооно.

3.1.1.5 400м, 800м, 1500м зайн уралдааны үед сүүлийн хоёр гараа нь 3.1.1.2-т заасны дагуу хуваарьлагдана.

3.1.1.6 Хэрвээ тэмцээний үеэр хоёр болон түүнээс олон урьдчилсан гараа гарахаар бол гараа болгонд дор хаяж гурван сэлэгч байхаар хуваарьлах бөгөөд ингэж хуваарьлахад зарим гараанд гурваас цөөн тамирчин байхыг зөвшөөрнө.

3.1.2 Тэмцээний бассейны замыг баруун талаас нь эхлэн дугаарлана. Мэдүүлсэн цагаараа хамгийн сайн цагтай тамирчин буюу багийг бассейны голын, сондгой тоотой зам дээр хуваарьлана. Дараагийн тамирчдыг түүний зүүн, баруун, зүүн, баруун гэх зарчмаар сөөлжлөн хуваарьлана. Ижил цагтай тамирчдыг шодон эрэмбийг нь тогтоож, уралдааны замын байрлалыг нь тогтооно.

## 3.2 Хагас болон шигшээ уралдаан

3.2.1 Хагас шигшээ уралдааны гарааны замыг 3.1.1.2 заасан зарчмаар хуваарьлана.

3.2.2 Урьдчилсан гараагүй байсан бол 3.1.2-т заасан зарчмаар замыг хуваарьлана. Урьдчилсан болон хагас шигшээ гараанууд зохион байгуулагдсан болсон тухайн уралдаануудын цагийн үзүүлэлтээр эрэмбэлж 3.1.2-т заасан зарчмаар байрлалыг тогтооно.

3.2.3 Хагас болон шигшээ уралдаанд ижил цагийн амжилттай тамирчдын аль нь оролцохыг шийдвэрлэх шаардлага үүсвэл тэдгээр тамирчдын дунд нэмэлт гарааг зохион байгуулна. Нэмэлт гарааг зохион байгуулах хугацааг тэмцээний зохион байгуулагчид болон тамирчдыг байлцуулан зөвшилцөж шийдвэрлэнэ. Дахиад тэнцсэн тохиолдолд дахин нэмэлт гарааг зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд хагас болон шигшээ уралдааны 1 болон 2 дугаар нөөц тамирчныг тогтоохын тулд нэмэлт гарааг зохион байгуулж болно.

3.2.4 Нэг буюу түүнээс олон тамирчин хагас болон шигшээ уралдаанд оролцох боломжгүй болсон тохиолдолд нөөц тамирчдыг өмнөх гараануудад үзүүлсэн цагийн амжилтаар нь эрэмбэлэн тэдний оронд уралдаанд оролцох эрхийг олгоно. Энэ тохиолдолд гарааны хуваарийг дахин хийнэ.

3.2.5 Тамирчид гарааныхаа өмнө Call room-д өөрийн оролцох гарааны байрлалыг баталгаажуулан мэдээлэл авах ёстой.



3.3 Тэмцээнийг зохион байгуулах хороо гарааны байрлалын хуваарийг зориулалтын програм ашиглан хийх шийдвэр гаргаж болно.

3.4 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээний 800м болон 1500м-ийн уралдаанаас бусад гарааг урьдчилсан болон шигшээ гараатай зохион байгуулна. 800м болон 1500м гарааг шууд шигшээ уралдаан болгож зохион байгуулна.

Бусад тэмцээнийг урьдчилсан болон хагас шигшээ гараагүй зохион байгуулна.

#### **4. ГАРАА**

4.1 Өврөөр даллах, мэлхий сэлэлт, эрвээхий сэлэлт болон ганцаарчилсан холимог сэлэлтийн уралдаан нь тамирчин гарааны тавцангаас ус руу үсрэн шумбаж эхлэнэ. Ерөнхий шүүгчийн урт үргэлжлэх шүглийн дохиогоор (Хоёрдугаар бүлэг 2.1.5 зүйл) тамирчид гарааны тавцан дээр гарч байрлалаа эзлэнэ. Гарааны шүүгч "Take your marks" гэсэн командыг өгөхөд тамирчид гарааны тавцангийн урд талд дор хаяж нэг хөлөө байрлуулж гарааны байрлалд нэн даруй шилжинэ. Гарны байрлал хаана ч байж болно. Бүх тамирчид хөдөлгөөнгүй болох үед гарааны шүүгч гарааны дохио өгнө.

4.2 Араар даллах болон холимог буухиа уралдааны гарааг уснаас эхлүүлнэ. Ерөнхий шүүгчийн эхний урт үргэлжлэх шүгэл дуугарах үед (Хоёрдугаар бүлэг 2.1.5 зүйл) тамирчид нэн даруй ус руу орно. Ерөнхий шүүгчийн хоёр дахь урт үргэлжлэх шүгэл дуугарах үед тамирчид ямар ч сааталгүй гарааны байрлалд шилжинэ (Хоёрдугаар бүлэг 6.1 зүйл). Бүх тамирчид гарааны байрлалаа эзэлсний дараа гарааны шүүгч "Take your marks" гэсэн команд өгнө. Бүх тамирчид хөдөлгөөнгүй болох үед гарааны шүүгч гарааны дохиог өгнө.

4.3 МУССХ-ны усан сэлэлтийн төрлийн бүх тэмцээний үед "Take your marks" гэсэн командыг англи хэл дээр өгөх бөгөөд гарааны тавцан тус бүр дээр суурилуулсан чанга яригчийн ашиглан гарааны дохиог өгнө.

4.4 Гарааны дохио өгөхөөс өмнө гараагаа эхлүүлсэн тамирчны гарааг цуцлана. Хэрэв тамирчны гарааг цуцлахаас өмнө гарааны дохио дуугарвал уралдааныг үргэлжлүүлж, уралдаан дууссаны дараа тамирчны гарааг цуцлана. Гарааны дохионы өмнө тамирчны гарааг цуцалсан тохиолдолд дохио өгөлгүй тухайн тамирчныг гарааны тавцангаас чөлөөлж, үлдсэн тамирчдыг дахин дуудаж, гарааг шинээр эхлүүлнэ. Ерөнхий шүүгч урт үргэлжлэх шүглийн дохио (араар даллах сэлэлтийн үед хоёр дахь урт шүглийн дохио) өгч гарааг дахин эхлүүлнэ.

#### **5. ӨВРӨӨР ДАЛЛАХ СЭЛЭЛТ**

5.1 Ганцаарчилсан холимог сэлэлт болон холимог буухиа уралдаанаас бусад тохиолдолд өврөөр даллах сэлэлт гэж тамирчин мэлхий, эрвээхий, араар даллах сэлэлтийн төрлөөс өөр сэлэлтийн ямар ч



төрөл, хэв маягаар сэлж болохыг ойлгоно.

5.2 Тамирчин замын төгсгөл бүрт болон барианы үед усан сангийн хананд биеийн аль нэг хэсгээр хүрэх ёстой.

5.3 Тамирчны биеийн аль нэг хэсэг нь уралдааны туршид усны гадаргуу дээр байх ёстой. Гэхдээ гарааны дараа болон эргэлт бүрийн дараа 15 метрээс илүүгүй зайд тамирчин шумбан сэлж болно. Энэ тохиолдолд 15 метрийн зай дуусахаас өмнө толгойн хэсэг усны мандал дээр гарсан байх ёстой.

## **6. АРААР ДАЛЛАХ СЭЛЭЛТ**

6.1 Сэлэгчид гарааны дохио өгөхөөс өмнө усан дотор гарааны хана руу харж эгнэн зогсох бөгөөд хоёр (2) гараараа гарааны бариулаас барьсан байна. Ус зайлуулах суваг болон түүний дээр зогсох, эсвэл ус зайлуулах хоолойн ирмэгийг хөлийн хуруугаар ороож зогсохыг хориглоно. Араар даллах сэлэлтийн гараанд хөлийн эвүүр ашиглаж байгаа тохиолдолд сэлэгчийн хөл тус бүрийн аль нэг хуруу гарааны хана эсвэл мэдрэгч хавтанд хүрсэн байна. Мэдрэгч хавтангийн дээд хэсэг дээр зогсохыг хориглоно.

6.2 Гарааны дохионы дараа болон эргэлт гүйцэтгэсний дараа сэлэгч 6.4-т заасан эргэлтийг хийхээс бусад тохиолдолд зөвхөн нуруу доош харсан байрлалаар түлхэж, сэлнэ. Араар даллах сэлэлтийн үед биеийн байрлал 90 хэмээс хэтрэхгүйгээр хоёр тийш савлан хөдөлж болно. Толгойны байрлал ямар ч байж болно.

6.3 Сэлэлгчийн биеийн аль нэг хэсэг уралдааны туршид усны мандал дээр байна. Харин сэлэгчийн толгойн хэсэг барианд орохын өмнөх таван (5) метрийн тэмдгийг өнгөрсөн тохиолдолд сэлэгч шумбалт хийн барианд орж болно. Мөн гараа болон эргэлт бүрийн дараа сэлэгч 15 метрээс ихгүй зайд шумбан сэлж болно. Зөвшөөрөгдсөн зай дуусахаас өмнө сэлэгчийн толгой усны мандал дээр гарсан байх ёстой.

6.4 Эргэлтийг гүйцэтгэх үед сэлэгчийн биеийн аль нэг хэсэг нь хананд хүрч байх ёстой. Эргэлтийн үед сэлэгч мөрөө босоогоор нь цээжний зүг эргүүлж, дараа нь эргэлтийг эхлүүлэхийн тулд нэг гараа татах эсвэл нэгэн зэрэг давхар гар татах боломжтой. Сэлэгч хананаас түлхэлт хийж дуусах үедээ араар даллах сэлэлтийн байрлалдаа буцаж орсон байх ёстой.

6.5 Сэлэгч барианд орохдоо барианы хананд нуруун дээрхи байрлал буюу араар даллах сэлэлтийн байрлалыг хадгалсан хэвээр хүрнэ.

## **7. МЭЛХИЙ СЭЛЭЛТ**

7.1 Гараа болон эргэлт бүрийн дараа сэлэгч шумбалт хийж байх үедээ гарын бүрэн таталтыг нэг удаа хийж болно. Гараа болон эргэлт бүрийн дараа мэлхий сэлэлтийн эхний хөлийн түлхэлтийг хийхээс өмнө нэг удаа эрвээхий сэлэлтийн цикл хийхийг зөвшөөрнө. Хоёр дахь удаагийн гарын таталт хамгийн өргөн хэсэгтээ хүрч дотогш чиглэхээс өмнө сэлэгчийн толгойн хэсэг усны мандалд гарсан байх ёстой.



7.2 Гарааны болон эргэлт бүрийн дараахи эхний гарын таталт эхлэх үед сэлэгчийн цээж доош харсан байдалтай байна. Эргэлтийн хананд хүрч эргэлт хийхээс бусад тохиолдолд сэлэгч нуруугаараа доош харахыг хориглоно. Эргэлтийн төгсгөлд сэлэгч хананаас салах үед цээж доош харсан л байвал эргэлтийг ямар ч байдлаар хийж болно. Гарааны болон уралдааны туршид цикл нь гарын нэг таталт, хөлийн нэг түлхэлт гэсэн дараалалтай байна. Гарны бүх хөдөлгөөн нь ямар нэг солбилцолгүй, тэгш хэмтэй байх ёстой.

7.3 Гарнуудыг усан дотор болон гадна цээжнээс урагш хамтад нь түлхэнэ. Барианы өмнөх сүүлийн таталт болон эргэлтийн өмнөх таталт, эргэлт хийх үеэс бусад тохиолдолд гарын тохой усан доор байна. Гараа усны гадаргуу дээр эсвэл доор буцааж авчрах ёстой. Гараа болон эргэлт бүрийн дараахи эхний таталтаас бусад үед гарыг бүсэлхийн шугмаас давуулан татаж болохгүй.

7.4 Бүрэн цикл бүрийн үед сэлэгчийн толгойн хэсэг усны мандал дээр гарсан байна. Хөлийн бүх хөдөлгөөн нь ямар нэг солбилцолгүй, тэгш хэмтэй байх ёстой.

7.5 Хөлийн түлхэх хөдөлгөөний үед хөлийн тавхайн хэсэг гадагш эргэсэн байрлалтай байна. Солбилцсон хөдөлгөөн болон доош чиглэсэн эрвээхий сэлэлтийн түлхэлтийг 7.1 хэсэгт зааснаас бусад тохиолдолд хориглоно. Эрвээхий сэлэлтийн доош чиглэсэн хөлийн түлхэлтээс бусад тохиолдолд хөлийн тавхай хэсэг усны мандлаас дээш гарч болно.

7.6 Бариа болон эргэлт бүрийн үеэр хананд хүрэх үед хоёр гар нь салангид, тэгш хэмтэй байх ёстой бөгөөд усны мандлаас дээр эсвэл доор байж болно. Эргэлт болон барианы өмнөх сүүлчийн таталтын дараа хөлийн түлхэлтгүй нэг удаагийн гарны таталтыг зөвшөөрнө. Хананд хүрэхийн өмнөх сүүлчийн бүрэн болон дутуу циклийн үеэр биеийн аль нэг хэсэг усны мандал дээр гарсан байх ёстой бөгөөд сүүлийн гарын таталтын дараа толгой усанд шумбаж болно.

## **8. ДАЛАЙН ГАХАЙ (ЭРВЭЭХИЙ) СЭЛЭЛТ**

8.1 Гараа болон эргэлт бүрийн дараахи эхний гарын таталтаас эхлэн сэлэгчийн цээжин хэсэг доош харсан байрлалтай байна. Эргэлтийн хананд хүрч эргэлт хийхээс бусад тохиолдолд сэлэгч нуруугаараа доош харахыг хориглоно. Эргэлтийн төгсгөлд сэлэгч хананаас салах үед цээж доош харсан л байвал эргэлтийг ямар ч байдлаар хийж болно.

8.2 Уралдааны туршид сэлэгч хоёр гараа усны мандал дээгүүр нэгэн зэрэг тэгш хэмтэйгээр урагш шидэх бөгөөд тэгш хэмтэйгээр усан доогуур буцааж татна.

8.3 Хөлийн дээш доош бүх хөдөлгөөнийг нэгэн зэрэг, тэгш хэмтэй хийх ёстой. Хөл болон хөлийн тавхай нь заавал ижил түвшинд байх шаардлагагүй боловч бие биенээсээ хамааралгүй солбилцох ёсгүй. Мэлхий сэлэлтийн хөлийн түлхэх хөдөлгөөнийг хориглоно.

8.4 Бариа болон эргэлт бүрийн үеэр хананд хүрэх үед хоёр гар нь салангид, тэгш хэмтэй байх ёстой





бөгөөд усны мандлаас дээр эсвэл доор байж болно.

8.5 Гараа болон эргэлтийн үеэр сэлэгч нэг болон түүнээс олон тооны хөлийн түлхэлт болон түүнийг усны мандал дээр гаргах зорилготой нэг удаагийн усан доорхи гарын таталт хийхийг зөвшөөрнө. Мөн гараа болон эргэлт бүрийн дараа сэлэгч 15 метрээс ихгүй зайд шумбан сэлж болно. Зөвшөөрөгдсөн зай дуусахаас өмнө сэлэгчийн толгой усны мандал дээр гарсан байх ёстой. Усанд сэлэгч нь дараагийн эргэлт эсвэл барианд орох хүртлээ усны мандал дээр байна.

## 9. ХОЛИМОГ СЭЛЭЛТ

9.1 Ганцаарчилсан холимог сэлэлтийн төрөлд сэлэгч дөрвөн төрлийн сэлэлтийг Эрвээхий, Араар даллах, Мэлхий сэлэлт, Өврөөр даллах сэлэлт гэсэн дарааллаар гүйцэтгэнэ. Сэлэлт тус бүр нийт зайны дөрөвний нэгийг (1/4) хамрах ёстой. Чөлөөт сэлэлтэд шилжих үед хананаас салахдаа нуруугаа доош харуулсан байхыг зөвшөөрөх боловч цээжний хэсэг босоо тэнхлэгийн шугмыг давах хүртэл ямар нэгэн хөлийн хөдөлгөөн хийхийг хориглоно.

9.2 Өврөөр даллах сэлэлтийн төрөлд сэлэгч нь эргэлт хийхээс бусад тохиолдолд цээжээ доош харуулан сэлнэ. Усанд сэлэгч нь ямар нэгэн хөлийн цохилт болон гарын таталт хийхээсээ өмнө цээжээ доош харуулсан байрлалдаа буцаж очих ёстой.

9.3 Холимог буухиа сэлэлтийн төрөлд тамирчид дөрвөн сэлэлтийн төрлийг Араар даллах, Мэлхий сэлэлт, Эрвээхий сэлэлт, Өврөөр даллах сэлэлт гэсэн дарааллаар гүйцэтгэнэ. Сэлэлт тус бүр нийт зайны дөрөвний нэгийг (1/4) хамрах ёстой.

9.4 Сэлэлтийг тухайн сэлэлтийн төрөлд хамаарах дүрмийн дагуу гүйцэтгэж дуусгана.

## 10. УРАЛДААН

10.1 Хувийн гараатай бүх уралдааныг хүйсээр ялгаж тусад нь явуулна.

10.2 Хувийн гараанд уралдаж байгаа тамирчин сэлж буй зайгаа бүрэн дуусгасан тохиолдолд гарааг тооцож амжилтыг бүртгэнэ. Дэлхийн усан спортын холбогдох дүрмийн дагуу сэлж буй зайгаа бүрэн дуусгаж чадаагүй тамирчны гарааг хүчингүй болгоно.

10.3 Тамирчид энэхүү дүрмийн Хоёрдугаар бүлгийн 1.5 зүйлд заасан тамирчны танилцуулга дуусмагц уралдааны хувцаснаас бусад бүх хувцсыг нэн даруй тайлах ёстой.

10.4 Тамирчин зөвхөн уралдаанаа эхлүүлсэн замаараа л сэлж уралдааныг дуусгах ёстой.

10.5 Тамирчин сэлэлтийн бүх төрөлд эргэлт хийх үедээ усан сангийн төгсгөлийн хананд заавал биеийн хэсгээр хүрэх ёстой. Эргэлтийг хананаас хийх ёстой бөгөөд усан сангийн доод хэсэгт алхалт хийх, түлхэлт авах хориглоно.

10.6 Өврөөр даллах сэлэлтийн төрөл болон холимог сэлэлтийн өврөөр даллах сэлэлтийн үед тамирчин





усан сангийн доод хэсэг дээр зогсвол гарааг хүчингүй болгохгүй. Харин усан сангийн доод хэсэг дээр алхалт хийхийг хориглоно.

10.7 Замын тусгаарлагч олсноос татахыг хориглоно.

10.8 Уралдааны замаасаа гарч бусад тамирчны замд орж саатуулах, эсвэл өөр ямар нэгэн байдлаар саад учруулсан тамирчны гарааг хүчингүй болгоно. Ерөнхий шүүгч энэ зөрчлийг санаатай үйлдсэн гэж үзвэл зөрчил гаргасан тамирчны багийн ахлагчид мэдэгдэж, хатуу сануулга өгнө.

10.9 Тухайн гараанд оролцоогүй тамирчин, уралдаан дуусахаас өмнө тэмцээн явагдаж байгаа усанд орсон тохиолдолд түүний дараагийн хуваарьт уралдаандаа оролцох эрхийг хасна.

10.10 Буухиа уралдааны баг бүрт дөрвөн тамирчин байна. Буухиа уралдааны багт дөрвөн (4) эрэгтэй, эсвэл дөрвөн (4) эмэгтэй тамирчин байна. Холимог буухиа уралдааны баг хоёр (2) эрэгтэй, хоёр (2) эмэгтэй тамирчнаас бүрдэх ёстой. Холимог буухиа уралдааны амжилтыг тамирчны хувийн амжилт болон рекорд амжилтанд бүртгэх боломжгүй.

10.11 Буухиа солилцоог гарааны тавцангаас эхлэх ёстой. Усан сангийн тавцангаас гүйлт хийж үсрэхийг хориглоно.

10.12 Буухиа уралдааны үед буухиаг хүлээн авч байгаа тамирчны хөл, өмнөх тамирчнаа барианы хананд хүрэхээс өмнө гарааны тавцангаас салсан байвал тус багийн амжилтыг хүчингүйд тооцно.

10.13 Бусад багуудын бүх тамирчид уралдаанаа дуусгахаас өмнө багийн тухайн ээлжинд сэлэхээр томилогдсон тамирчнаас өөр тамирчин усан санд орсон тохиолдолд тус багийн амжилтыг хүчингүйд болгоно.

10.14 Буухиа багийн гишүүд, тэдгээрийн уралдах дарааллыг уралдааны өмнө мэдүүлсэн байх ёстой. Буухиа багийн гишүүн уралдаанд зөвхөн нэг удаа оролцож болно. Буухиа багийн бүрэлдэхүүнийг тухайн тэмцээнд оролцож буй тамирчдаас бүрдүүлсэн тохиолдолд тэмцээний урьдчилсан шат ба шигшээ уралдааны хооронд өөрчилж болно. Буухиа багийн тамирчид мэдүүлсэн дарааллаараа сэлээгүй бол амжилтыг хүчингүйд болгоно. Зөвхөн эмчийн магадлагааг үндэслэн тамирчдын дарааллыг өөрчлөх асуудлыг Ерөнхий шүүгч шийдвэрлэж болно.

10.15 Уралдаанаа дуусгасан тамирчин болон буухиа уралдааны үед өөрийн зайгаа дуусгасан тамирчин нь уралдаанаа дуусгаж амжаагүй байгаа бусад тамирчдад саад учруулахгүйгээр аль болох хурдан усан санг орхих ёстой. Энэ заалтыг зөрчсөн тамирчныг, буухиа уралдааны үед тус тамирчны багийн амжилтыг хүчингүйд тооцно.

10.16 Хэрэв хэн нэгний гаргасан алдаа нь тамирчны амжилтанд муугаар нөлөөлсөн гэж үзвэл Ерөнхий шүүгч тус тамирчныг дараагийн гараанд дахин гарахыг зөвшөөрөх эрхтэй. Хэрэв алдаа нь сүүлийн гараанд эсвэл шигшээ уралдааны үед гарсан бол Ерөнхий шүүгч тус гарааг дахин уралдуулж болно.

10.17 Зүрхний хэмнэл тохируулагч болон түүнтэй адил үйлчилгээтэй ямар нэгэн төхөөрөмж ашиглахыг



хориглоно.

## 11. ХУГАЦАА

11.1. Зөвхөн Ерөнхий шүүгчийн томилсон хүн л автомат цагийн төхөөрөмжийн ажиллагааг хариуцан ажиллана. Автомат цагийн төхөөрөмжийн бүртгэсэн цагийг тамирчдын эзэлсэн байр болон ялагчийг тодруулах болон зам болгоны цагийн үзүүлэлтийг тодорхойлоход ашиглана. Автомат цагийн төхөөрөмжийн бүртгэсэн цагийн үзүүлэлтийг цагийн шүүгчийн бүртгэсэн үзүүлэлтээс давуу үзэж эцсийн шийдвэр болгон ашиглана.

Автомат цагийн төхөөрөмж эвдэрсэн эсвэл доголдол үүссэн, тамирчин барианд орох үедээ цагийг зогсоож чадаагүй бол цагийн шүүгчийн бүртгэсэн цагийг албан ёсны цаг гэж үзнэ (Хоёрдугаар бүлгийн 13.3 зүйлийг харна уу). Нэг замын бүх цагны төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд тамирчныг дахин гараанд гаргаж болно.

11.2 Автомат цагийн төхөөрөмжийг ашиглаж байгаа тохиолдолд тамирчны амжилтыг секундын 1/100 нэгж нарийвчлалтай бүртгэнэ. Секундын 1/100 нэгж нарийвчлалтай бүртгэгдсэн цагийн үзүүлэлт нь ижил тамирчдыг адил байр эзэлсэн гэж үзнэ. Цахим онооны самбар дээр харуулсан цаг нь секундын 1/100-ийн нарийвчлалтай байх ёстой.

11.3 Шүүгчийн удирдан ажиллуулж тамирчны амжилтыг бүртгэж байгаа цагийг гар цаг гэж нэрлэнэ. Уралдааны зам тус бүрт шүүгчдийн зөвлөлөөс томилогдсон гурван шүүгч гар цагийг бүртгэнэ. Бүх цагууд бүрэн гүйцэд ажиллагаатай байгаа эсэхийг зохион байгуулах хороо урьдчилан шалгасан байна. Гар цагийг секундын 1/100 нэгж нарийвчлалтай бүртгэнэ. Автомат цагийн төхөөрөмж ашиглаагүй тохиолдолд дараахи байдлаар албан ёсны цагийг эцэслэн тогтооно.

11.3.1 Гурван (3) цагны хоёр (2) нь ижил цагийг зааж, гурав дахь нь өөр байвал хоёр ижил цагийг албан ёсны цаг байна.

11.3.2 Гурван (3) цаг гурвуулаа өөр цагийг зааж байвал завсрын цагийг тэмдэглэсэн цаг нь албан ёсны цаг байна.

11.3.3 Гурав (3) цагны хоёр (2) нь л цагийг зааж байгаа бол дундаж цаг нь албан ёсны цаг байна. Хэрэв цаг нь 1000-ны нэгж нарийвчлалтай байвал хамгийн сүүлийн оронг нь тоймлолгүй хасаж цагийн үзүүлэлтийг авна.

11.4 Тамирчны амжилтыг уралдааны үеэр эсвэл уралдааны дараа хүчингүй болгосон бол амжилтыг хүчингүй болгосон тухай албан ёсны дүнд бүртгэх боловч цагийн үзүүлэлт болон байрыг зарлаж тэмдэглэхгүй.

11.5. Буухиа уралдааны амжилтыг хүчингүй болгосон бол амжилтыг хүчингүй болгох алдааг гаргах хүртэлх багийн гишүүдийн хугацааг тус тусад нь бүртгэж албан ёсны дүн болгоно.



11.6 Буухиа уралдааны үеэр гарааг эхлүүлсэн тамирчны 50 болон 100 метрийн зайг туулсан цагийг албан ёсны дүнгийн хамт бүртгэж, танилцуулна.

## 12. УЛСЫН РЕКОРД

12.1 Хорин таван (25) метрийн усан сангийн Улсын рекорд амжилт болон Өсвөр үе, залуучуудын насны бүлгийн рекорд амжилтыг доорхи төрөл зайд, эрэгтэй эмэгтэй хүйсийн ангилалд тогтоож болно.

Өврөөр даллах сэлэлт	50, 100, 200, 400, 800 болон 1500 метр
Араар даллах сэлэлт	50, 100 болон 200 метр
Мэлхий сэлэлт	50, 100 болон 200 метр
Эрвээхий сэлэлт	50, 100 болон 200 метр
Холимог сэлэлт	100, 200 болон 400 метр
Өврөөр даллах сэлэлтийн буухиа	4 x 50, 4 x 100 болон 4 x 200 метр
Холимог сэлэлтийн буухиа	4 x 50 болон 4 x 100 метр
Холимог буухиа	4 x 50 болон 4 x 100 метр Өврөөр даллах сэлэлтийн буухиа 4 x 50 болон 4 x 100 метр Холимог сэлэлтийн буухиа

12.2 Буухиа багийн гишүүд нэг багт харьяалагддаг байх ёстой.

12.3 Усан сангийн зам тус бүрийн уртыг урьдчилан хэмжиж баталгаажуулах ажлыг тэмцээнийг зохион байгуулах хороо хийнэ.

12.4 Хөдөлгөөнт хаалт ашиглаж байгаа тохиолдолд усан сангийн замын уртыг рекорд амжилт тогтоогдсны дараа дахин баталгаажуулах ёстой.

12.5 Улсын болон өсвөр үе, залуучуудын насны бүлгийн рекорд амжилтыг зөвхөн автомат цагийн төхөөрөмж, эсвэл автомат цагийн төхөөрөмжид доголдол гарсан үед хагас автомат төхөөрөмжөөр цагийг бүртгэсэн тохиолдолд л тооцно.

12.6 Тамирчин стандартын шаардлага хангасан усны хувцас хэрэглэсэн тохиолдолд л Улсын болон өсвөр үе, залуучуудын насны бүлгийн рекорд амжилтыг нь тооцно. (Хоёрдугаар бүлгийн 15.2 зүйлийг үзнэ үү).

12.7 Секундын 1/100 нэгжийн нарийвчлалтай цагийн ижил амжилт гаргасан тамирчдыг рекорд амжилтыг хамтран эзэмшигч гэж нэрлэнэ. Зөвхөн уралдаанд түрүүлсэн тамирчны цагийг л Улсын рекорд амжилтанд тооцох боломжтой. Тамирчид ижил цагийн амжилтаар рекорд тогтоосон бол тамирчин бүрийг уралдаанд түрүүлсэн гэж үзнэ.

12.8 Зөвхөн 3 гр/литрээс бага давстай усанд тогтоосон рекорд амжилтыг хүлээн зөвшөөрнө. Бүх төрлийн нуур цөөрмийн усанд тогтоосон рекорд амжилтыг хүлээн зөвшөөрөхгүй.



12.9 Холимог буухиа уралдаанаас бусад төрлийн буухиа уралдааны эхний тамирчны амжилтыг Улсын болон Өсвөр үе, залуучуудын насны бүлгийн реорд амжилтанд бүртгэж болно. Хэрэв буухиа багийн эхний тамирчин энэ хэсэгт заасны дагуу рекорд амжилт тогтоосон бол түүний дараа гарсан тамирчдын зөрчлийн улмаас буухиа багийн амжилтыг хүчингүй болгосон нь, түүний рекорд амжилтыг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.

12.10 Насанд хүрэгчдийн болон Өсвөр үе, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн болон МУССХ-ны бусад тэмцээний үеэр тогтоосон улсын рекорд амжилтыг автоматаар баталгаажуулна.

12.11 Улсын болон Өсвөр үе, залуучуудын насны бүлгийн рекорд амжилт тогтоосон тамирчинд МУССХ-ны Ерөнхийлөгчийн гарын үсэг бүхий димломыг гардуулна. Буухиа сэлэлтийн төрөлд рекорд амжилт тогтоосон багийн бүх гишүүдэд болон тухайн багийн харьяалагддаг байгууллага, клубт дипломыг гардуулна.

12.12 Тэмцээний хөтөлбөрт усан сэлэлтийн шинэ төрөл зай нэмэгдсэн тохиолдолд МУССХ-ны Удирдах зөвлөл нь холбогдох мэрэгжлийн зөвлөлүүдийн тусламжтай тухайн төрөл зайны зорилтот цагийг тогтооно. Хэрэв тамирчин тухайн зорилтот цагаас бага цагийн амжилт гаргавал тухайн амжилтыг рекорд амжилт гэж тооцож бүртгэнэ.

12.13 МУССХ-ны тэмцээний үеэр Дэлхийн болон Дэлхийн залуучуудын насны рекорд амжилт тогтоогдсон бол тэмцээнийг зохион байгуулах хороо нь Дэлхийн усан спортын албан ёсны маягтыг ашиглан рекорд амжилтыг бүртгүүлэх өргөдлийг Дэлхийн усан спортын холбоо буюу World Aquatics-д гаргана. Бүртгүүлэх өргөдлийг Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны Тэмцээний дүрмийн (Competition regulations) хоёрдугаар бүлгийн 12.14-12.20 зүйлүүдэд заасан журмыг баримтлан гаргана.

### **13. АВТОМАТ ЦАГИЙН ТӨХӨӨРӨМЖИЙГ АШИГЛАХ ЖУРАМ**

13.1 МУССХ-ны бүх тэмцээнд автомат цагийн төхөөрөмжийг (World Aquatics, Competition regulations II.16.3) ашиглана. Усанд сэлэлтийн автомат хэрэгсэл ашиглаж байгаа үед тухайн төхөөрөмжийн тогтоосон цаг, байр, буухиа уралдааны шилжилтийн тэмдэглэлийг цагийн болон эргэлтийн шүүгчийн шийдвэрээс давуу үзэж албан ёсны шийдвэр болгон хэрэглэнэ.

13.2 Автомат цагийн төхөөрөмж нь тухайн гарааны нэг буюу хэд хэдэн тамирчны эзэлсэн байр эсвэл цагийг тэмдэглэж чадаагүй тохиолдолд:

13.2.1 Автомат цагийн төхөөрөмжийн тэмдэглэсэн боломжит бүх цаг болон эзэлсэн байрын тэмдэглэлийг бүртгэж авна.

13.2.2 Гар цагийн үр дүнд гарсан бүх эзэлсэн байр болон цагийн үзүүлэлтийг бүртгэнэ

13.2.3 Дээрхи тэмдэглэлүүдийг үндэслэн албан ёсны эзэлсэн байрыг дараахи байдлаар тогтооно:



13.2.3.1 Автомат цагийн төхөөрөмжийн тэмдэглэсэн байр болон цагийн үзүүлэлттэй тамирчид төхөөрөмжийн тэмдэглэсэн байр болон цагийн үзүүлэлтээ хадгална.

13.2.3.2 Автомат цагийн төхөөрөмжийн тэмдэглэсэн байргүй боловч цагийн үзүүлэлттэй тамирчдыг бусад тамирчдын автомат цагийн төхөөрөмжийн цагтай тамирчдын хугацаатай харьцуулан эзэлсэн байрыг тогтооно.

13.2.3.3 Автомат цагийн төхөөрөмжийн тэмдэглэсэн байр болон цагийн үзүүлэлтгүй тамирчдын хагас автомат цагийн төхөөрөмж эсвэл шүүгчийн гар цагийн үзүүлэлтийг нь бусад автомат цагийн төхөөрөмжийн цагтай тамирчдын хугацаатай харьцуулан эзэлсэн байрыг тогтооно.

13.3 Албан ёсны цагийг дараах байдлаар тогтооно.

13.3.1 Автомат цагийн төхөөрөмжийн цагтай бүх тамирчдын албан ёсны цаг нь тухайн цаг байна.

13.3.2 Автомат цагийн төхөөрөмжийн цаггүй бүх тамирчдын албан ёсны цаг нь Хагас автомат цагийн төхөөрөмж эсвэл гар цагийн цагт тэмдэглэсэн цаг байна.

13.4 Гараанд эзэлсэн байрны дарааллыг тодорхойлохын тулд дараахи зүйлийг хийнэ.

13.4.1 Нийт тамирчдын эзэлсэн байрны дарааллыг албан ёсны цагийг харьцуулан тогтооно.

13.4.2 Нэг буюу хэд хэдэн тамирчны албан ёсны цаг(ууд) тэнцсэн бол ижил цагтай бүх тамирчид адил байр эзэлсэн гэж үзнэ.

13.4 Тэмцээний үеэр автомат цагийн төхөөрөмжид ноцтой гэмтэл саатал гарсан бол гар цагийг ашиглан тэмцээнийг үргэлжлүүлнэ.

## 14. НАСНЫ АНГИЛАЛ

14.1 МУССХ-ны Усан сэлэлтийн Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 14 болон түүнээс дээш насны тамирчид оролцоно.

14.2 МУССХ-ны бусад бүх тэмцээнийг насны бүлэгтэй зохион байгуулна.

14.3 Усан сэлэлтийн өсвөр үе, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдын насыг тэмцээний жилийн 12-р сарын 31-ний байдлаар тогтоож охид, хөвгүүдийн ангилалаар зохион байгуулна. Тамирчдыг доорхи байдлаар насны бүлэгт хуваана:

- 7-8 нас
- 9-10 нас
- 11-12 нас
- 13-14 нас



- 15-16 нас
- 17-18 нас

14.3 МУССХ-ны 2 болон 3-р зэрэглэлийн тэмцээнүүдийг доорхи насны бүлгээр, эрэгтэй эмэгтэй ангилалаар зохион байгуулна.

- 7-8 нас
- 9-10 нас
- 11-12 нас
- 13-14 нас
- 15-16 нас
- 17- түүнээс дээш нас

## **15. УСНЫ ХУВЦАС, ХЭРЭГСЭЛ**

15.1 Усанд сэлэлтийн тэмцээний эрэгтэй усны хувцасны дээд хэсэг хүйснээс дээш, доод хэсэг өвдөгнөөс доош байж болохгүй. Эмэгтэйчүүдийн хувьд усны хувцас нь хүзүүг халхалж, дээд хэсэг мөрнөөс дээш, доод хэсэг өвдөгнөөс доош байж болохгүй. Усны хувцас нь нэхмэл материалаар хийгдсэн байх ёстой.

15.2 Тэмцээний үеэр тамирчин хурд, хөвөх чадвар, тэсвэр хатуужилд нь туслах ямар нэгэн төхөөрөмж, усны хувцас ашиглахыг хориглоно. Мэдээлэл цуглуулах зорилгоор автоматжуулсан мэдээлэл цуглуулах төхөөрөмжийг ашиглахыг зөвшөөрнө. Автоматжуулсан мэдээлэл цуглуулах төхөөрөмжийг тамирчин руу өгөгдөл, дуу авиа, дохио дамжуулахад ашиглахгүй бөгөөд тэдний хурдыг нэмэгдүүлэхэд ашиглаж болохгүй. Нүдний шил зүүж болно. Гэмтлийн улмаас хоёроос илүүгүй хөлийн хурууг нааж болно. Ерөнхий шүүгч зөвшөөрснөөс бусад тохиолдолд тамирчин бие дээрээ ямар нэг наалт наахыг хориглоно.

15.3 Улсын рекорд амжилтыг (Өсвөр үе, залуучуудын насны бүлгийн рекорд амжилт, Мастеруудын рекорд амжилтыг оруулаад) зөвхөн зөвшөөрөгдсөн усан сэлэлтийн хувцас хэрэглэсэн тохиолдолд л МУССХ хүлээн зөвшөөрнө.

МУССХ нь тамирчнаас рекорд амжилтыг тогтоох үедээ өмсөж байсан усны хувцсаа шалгуулах хүсэлт гаргаж болно.

## **16. УСАН САН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

16.1 Ерөнхий шаардлагууд

16.1.1 МУССХ-ны тэмцээнийг зохион байгуулах 50,000 метрийн усан сангийн урт нь эхлэл болон эргэлтийн хананд автомат цагийн төхөөрөмжийн мэдрэгч хавтанг суурьлуулсны дараа хоёр хавтангийн хоорондох зай 50,000 метр байх шаардлагыг хангасан байна.



16.1.2 МУССХ-ны тэмцээнийг зохион байгуулах 25,000 метрийн усан сангийн урт нь эхлэл болон эргэлтийн хананд автомат цагийн төхөөрөмжийн мэдрэгч хавтанг суурьлуулсны дараа хоёр хавтангийн хоорондох зай 25,000 метр байх шаардлагыг хангасан байна

16.1.3 50,000 м-ийн усан сан дахь зөвшөөрөгдөсөн хүлцэх хэмжээ нь мэдрэгч хавтанг суурьлуулсны дараа +0,010 ба -0,000 метр байна. Эхлэл болон эргэлтийн хананд мэдрэгч хавтан бүхий усан сангийн урт багадаа 50,020 метр, ихдээ 50,030 метр байна.

16.1.4 25,000 м-ийн усан сан дахь зөвшөөрөгдөсөн хүлцэх хэмжээ нь мэдрэгч хавтанг суурьлуулсны дараа +0,010 ба -0,000 метр байна. Эхлэл болон эргэлтийн хананд мэдрэгч хавтан бүхий усан сангийн урт багадаа 25,020 метр, ихдээ 25,030 метр байна.

Зөвхөн нэг хананд нь мэдрэгч хавтан суурьлуулсан усан сангийн урт багадаа 25,010 метр, ихдээ 25,020 метр байна.

16.1.5 Дээрхи бүх хүлцэх хэмжээ нь усны гадаргуугаас дээш 0.300 метр, усны мандлаас доош 0.800 метр хүртэл тогтвортой байх ёстой.

Эдгээр хэмжилтийг хэмжил зүйн мэрэгжлийн байгууллагаар хийлгэж баталгаажуулна.

16.1.6 Усан сангийн өргөн нь Хоёрдугаар бүлгийн 16.1.9-ийн заалтад нийцсэн байх ёстой.

16.1.7 Усан сангийн гүн нь гарааны тавцантай талдаа хамгийн багадаа 1.35 метр гүн байх бөгөөд хананаас 1.0 метрээс 6.0 метр хүртэл үргэлжлэх ёстой. Усан сангийн бусад хэсэгт хамгийн багадаа 1.0 метр гүн байх шаардлагатай.

16.1.8 Усан сангийн хана хатуу, тамирчид эргэлт хийх үедээ хальтрахаас сэргийлсэн материалаар хийгдсэн байх ёстой бөгөөд усны мандалтай 90 хэмийн тэгш хэмтэй байна. Хана болон усны мандал хоёрын тэгш хэмийн зөвшөөрөгдөх хүлцэх хэмжээ нь  $\pm 0.3$  хэм байна.

16.1.9 МУССХ-ны тэмцээнийг зохион байгуулах усан сан хамгийн багадаа 4 замтай байх бөгөөд зам хоорондын өргөн нь хамгийн багадаа 2.5 метр байх шаардлагатай.

16.1.10 Зам тусгаарлагч олс нь давалгааг хангалттай хэмжээнд бууруулах боломжтой, Дэлхий усан спортын холбоо (World Aquatics)-ны дүрмийн Хоёрдугаар бүлгийн 16.1.7 зүйл дэх ерөнхий шаардлагыг хангасан байна.

16.1.11 Гарааны тавцан нь усны мандлаас 0.5-0.75 метрийн өндөрт бат бөх суурьласан байх бөгөөд тавцангийн хэмжээ хамгийн багадаа 0.5 метр х 0.5 метр хэмжээтэй, хальтардаггүй материалаар бүрхэгдсэн байх ёстой. Тавцангийн налуу 10 хэмээс хэтрэхгүй бөгөөд тавцан нь тохируулж болох арын хавтан болон хажуу талдаа бариул хэсэгтэй байж болно. Тавцангийн доод хэсэгт араар даллах сэлэлтийн гараанд зориулсан бариул усны мандлаас дээш 0.3-0.6 метрийн өндөрт суурьлагдсан байх ёстой.

16.1.12 Гарааны тавцангуудыг баруун гар талаас (усан сан руу харж зогсоод) эхлэн дугаарлах бөгөөд



дөрвөн талд нь дугаарыг сайн сайн харагдахаар тэмдэглэсэн байна. Мэдрэгч хавтангийн дээд талд мөн дугаар байрлуулж болно.

16.1.13 Араар даллах сэлэлтийн эргэлтийн тугийг усан сангийн мандлаас 1.8 метрийн өндөрт, эхлэл болон эргэлтийн хананы төгсгөлөөс 5.0 метрийн зайд байрлуулна. Мөн боломжтой бол хананаас 15.0 метрийн зайд зам тусгаарлагч олс бүр дээр ялгах тэмдэг тавьсан байна.

16.1.14 Араар даллах сэлэлтийн хөлийн ивүүр нь:

- Усны түвшнээс дээш 4 см болон доош 4 см байхаар тохируулах боломжтой байх ба энэ хязгаараас гадуур ашиглахыг хориглоно
- Хамгийн багадаа 65 см урттай
- 8 см өндөр, 2 см-ын өргөнтэй, 10 хэмийн налуутай байна

16.1.15 Усны температур 25 хэмээс 28 хэм хүртэл байна.

16.1.16 Тэмцээний үеэр усан сан дахь ус тогтмол түвшинд байх ёстой бөгөөд мэдэгдэхүйц хөдөлгөөнгүй байх ёстой. Мөн усны тунгалаг байдал болон эрүүл ахуйн шаардлага нь Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартыг хангасан байна.

Хөвөгч сагсан бөмбөгийг (зөв хөвөх хүчийг олж авахын тулд 6 литр усаар дүүргэсэн) нэг чиглэлд 60 секундын дотор 1,25 м-ээс дээш хөдөлгөх усны хөдөлгөөнийг "Үлэмж хөдөлгөөнтэй" гэж тодорхойлдог.

16.1.17 Усны давсжилт нь 3гр/литрээс ихгүй байх бөгөөд рекорд амжилтыг зөвхөн энэ шаардлагыг хангасан тохиолдолд л хүлээн зөвшөөрнө. Ямар ч төрлийн давст нуур, цөөрмийн усанд тогтоосон рекорд амжилтыг хүлээн зөвшөөрөхгүй.

16.1.18 Гэрэлтүүлэг нь усан сангийн дотор болон гадна талд тамирчдын үзэгдэх орчинд сөргөөр нөлөөлөхөөргүй хэмжээнд байна.

16.1.19 Замын тэмдэглэгээ нь бараан өнгөтэй байх ба эгнээ тус бүрийн голд усан сангийн шалан дээр байрлуулж болно.

16.1.20 МУССХ-ны тэмцээн зохион байгуулах усан сан болон түүний тоног төхөөрөмжүүд нь Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны Тэмцээний дүрэм (Competition regulations)-ийн Хоёрдугаар бүлгийн 16.1 зүйлд заасан стандарт шаардлагад нийцэж байх шаардлагатай бөгөөд тамирчдын амжилтанд сөргөөр нөлөөлөхгүй зарим шаардлагуудыг Тэмцээнийг зохион байгуулах хорооны шийдвэрээр хангахгүй байж болно. Тэмцээн зохион байгуулах хорооны энэхүү шийдвэр нь тамирчдын шударга өрсөлдөөний зарчимд саад болохоор байж болохгүй.